

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-35
<hr/>	
1. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	6-8
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдээдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	8-24
3. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	24-35

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Найдалаа, Ч.Ундрэм;
Чөлөөтэй: Б.Батбаатар, Л.Мөнхбаатар, Н.Учрал, О.Цогтгээрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа, А.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2026.04.29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүнээс 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газраас 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах

тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 18 гишүүнээс 2026.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүнээс 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай /Анхдагч хууль/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 14 гишүүнээс 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 4
Бүгд: 19
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21

76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21

76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Монгол Улсын Засгийн газраас 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваа-Очир, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, А.Энхбат, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Г.Билгүүн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Одхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга

Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, зөвлөх Д.Энхбаяр, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүүгийн газрын дарга Т.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Алтангэрэл, Д.Энхтуяа, Ч.Лодойсамбуу, Б.Жавхлан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Төсвийн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Эдийн засгийн байнгын хороодын хуралдаанд тус тус танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваа-Очир, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Г.Билгүүн, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтуяа, мөн зөвлөлийн Захиргаа, удирдлагын газрын дарга Л.Санжрагчаа, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга Г.Аззаяа, мөн газрын комиссар Э.Мөнх-Ирээдүй, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын

газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Алтангэрэл, Д.Энхтуяа, С.Зулпхар, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваа-Очир нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 52 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 24 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/-ны 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдааны ирцэд Оюунсайханы Алтангэрэл, Жадамбын Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа, Болдын Жавхлан, Эрдэнэбилэгийн Одбаяр, Баттогтохын Чойжилсүрэн, Доржзовдын Энхтуяа, Дашзэвгийн Амарбаясгалан, Жигжидийн Батжаргал, Сандагийн Бямбацогт, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Бөхчулууны Пүрэвдорж, Өлзийхүүгийн Шижир, Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Лувсаннямын Гантөмөр, Нямтайширын Номтойбаяр, Цэвэгдоржийн Туваан, Баттөмөрийн Энхбаяр нарын гишүүд хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 5 асуудал байгаа. Үүний 1 дүгээрт Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал. 2-т Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл. 3.Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 4.Байнгын хорооны тогтоолын төсөл, энэ цаглавар батлах тухай байгаа. 5-д бусад гэсэн эдгээр асуудлууд байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Энд тодруулж хэлэхэд энэ бусад буюу 5 дээр орж ирэхээр төлөвлөж байсан асуудал хараахан өнөөдрийн хуралдаанаар оруулах хэмжээнд бэлэн болоогүй байгаа. Мөн үргэлжлүүлж бэлтгэл ажил хангах зүйлүүд байгаа учраас хойшлуулах саналтай байгаа. Энэ юу байгаа Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлд нэр дэвших, тэр ажлын хэсэг ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар хуралдаанд танилцуулах хэмжээнд бэлэн болоогүй байгаа учраас нэг удаа хойшлуулах ийм саналтай байгаа. Өөр санал байхгүй бол ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх

эсэх асуудал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан ТББХ хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Улсын Их Хурал /УИХ/-д өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Батжаргал гишүүн, Баярмаа гишүүн, Гантөмөр гишүүн, Номтойбаяр гишүүн, Туваан гишүүн, Чойжилсүрэн гишүүн, Энхбаяр гишүүд ирцэд бэлдэнэ үү, санал хураалтын ирцэд бэлдэнэ үү. Гишүүд санал хураалтад бэлэн боллоо. Гишүүд анхааралтай байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 14 гишүүн буюу 73,7 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин нарын 6 гишүүнээс 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн орсноос 14 гишүүн зөвшөөрч, 73,7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Засгийн газраас 2026 оны 4 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 13 гишүүн зөвшөөрч, 68,4 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнх Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл нарын 18 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, зөвшөөрсөн байна, 73,7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл болон дагалдах хуулийн, дагалдах бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 14 гишүүн зөвшөөрч дэмжлээ, 73,7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа нарын 13 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 15 гишүүн зөвшөөрч дэмжсэн байна, 78,9 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Засгийн газраас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 11 гишүүн зөвшөөрч дэмжсэн байна, 57,9 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Засгийн газраас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 16 гишүүн зөвшөөрч дэмжсэн байна, 76,2 хувиар уг санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Засгийн газраас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 16 гишүүн зөвшөөрч, дэмжсэнээр 76,2 хувиар уг санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Засгийн газраас 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 13 гишүүн зөвшөөрч дэмжсэн байна, 61,9 хувиар уг санал дэмжигдлээ.

13.36 цаг

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэж заасан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Д.Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр, Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, З.Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, П.Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга.

Сангийн яамнаас Б.Анар Сангийн яамны ТНБД, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөгжлийн хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газраас Үйлстөгөлдөр дарга Ерөнхийлөгчийн иргэдтэй хийх уулзалт дээр явж байгаа учраас түр чөлөө авсан байгаа, амжиж ирвэл оролцохоо мэдэгдсэн байгаа. Улсын Их Хурлын Тамгын газраас Ц.Одхүү Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/-аас Т.Гантогтох ЗГХЭГ-ын Хүний нөөцийн газрын дарга, Ш.Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга. Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ээс Г.Билгүүн Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Билгүүн дарга байна уу? Билгүүн дарга байна уу? Төрийн албаны зөвлөл /ТАЗ/-өөс Л.Цэдэвсүрэн дарга ТАЗ-ийн дарга, Цэдэвсүрэн дарга ирсэн үү? Монгол Улсын Ёс зүйн хороо Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/-өөс Ц.Ариунболд генерал ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга, Сонгуулийн ерөнхий хороо /СЕХ/-ноос Д.Даваа-Очир СЕХ-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нарийн бичгийн дарга, Д.Бат-Эрдэнэ СЕХ-ны Тамгын газрын дарга.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Н.Ууганбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, ирчихсэн байсан даа. Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. Баярлалаа. Монгол Улсын Шадар сайдын ажлын албанаас Б.Мөнх-Оргил Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Г.Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал, Т.Мөнх-Эрдэнэ ОБЕГ-ын Санхүүгийн газрын дарга, дэд хурандаа, Мөнх-Эрдэнэ дэд хурандаа. С.Батбаатар Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Д.Энхбаяр Монгол Улсын Шадар сайдын зөвлөх, Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Б.Билгүүн Монополын эсрэг газрын дарга ийм бүрэлдэхүүнтэй хүмүүс ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл нэг зүйлтэй. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно. Энэ дээр тайлбар хэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.12 дахь хэсэгт гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно. 39.13 дахь хэсэгт гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 2 минутаас илүүгүй байна гэж заасан байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Доржзовдын Энхтуяа гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүнээс асуултаа эхэлье.

А.Ариунзаяа: Хэдийгээр энэ төсвийн хүрээ 9-хөн тооны хүрээнд явагддаг ч гэсэн цаана нь макро бүхий л энэ бодлого явж байдаг учраас би Энхбаяр сайдаас асуумаар байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөхгүй юм уу? Төсвийн тодотгол та хэд энэ 6 сард өргөн барихаар боллоо, зөвшөөрлөө авлаа гэж та ярилцлага өгсөн байсан. Тэгэхээр үүн дээрээ яг энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа өөрчилж, энэ өөрөө өөртөө чөдөр тушаа тавьсан энэ заалтуудыг засахгүй юм уу? Ялангуяа энэ гадаад зээллэг ашиглалттай холбоотой. Өрийн тааз 60 хувь байх ёстой ДНБ-ний 60 хувь байх ёстой. Одоо бол 40 хувьтай байгаа. Тэгэхээр 20-ийн орон зай байгаа гэж ярьж байгаа. Гэхдээ төсвийн Тогтвортой байдлын хуулиараа эргээд нөгөө өөрийн өөрөө чөдөр тушаа тавьчихсан, өөрсдөө энэ зээлээ ашиглаж чадахгүй, урсгал зардал нь давчхаад байгаа учраас өнөөдөр яг ийм нөхцөл байдалтай байгаад байна шүү дээ.

Хэдий болтол Улсын Их Хурлын гишүүдийг юу гэдэг юм бэ дээ, одоо нөхцөл байдал ямар байгаа вэ гэдгийгээ хаалттай ч гэсэн хамаагүй чуулганаар хэлэлцмээр байна. Өнөөдөр ЗГ цалингаа чадан ядан тавьж байгаа, яамнууд бусад аливаа бүхий л энэ зардлууд нь явахгүй байгаа. Төсөв маш хүнд нөхцөл байдалд байгаа. Тэгээд ердөөсөө энэ нөхцөл байдлаа хэлэхгүй болохлоор гишүүдийн өргөн барьж байгаа хуульч ч тэр, хэлж байгаа үг, ярилцлага ч тэр дандаа төсвийн зардлыг нэмэгдүүлсэн попорсон, дандаа ийм л чиглэл байгаад байгаа байхгүй юу. Тэгээд ердөөсөө нөгөө бодит мэдээлэл байхгүй байгаад байна. Тэгэхээр энийг гишүүддээ нөхцөл байдал ямар байгаа вэ гэдгийгээ нэг мэдүүлж өгөөч. Дефолт зарлах хэмжээндээ хүрчхээд байна шүү.

Гадаад зээллэгтэй холбоотой 2 хуулийг яаралтай өргөн, 2 төслийг явуулах хуулийг та хэд маань яаралтай өргөн барихаар болсон гэж өнгөрсөн баасан гарагт ярьж байсан. Сая ЗГ-аар оров уу? Эрдэнэбүрэний усны цахилгаан станц, газрын тосны энэ үйлдвэрийн зээллэгийг явуулах, яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг ЗГ-аас сая шийдвэрлэв үү? Сэлбийг орхичихсон уу? Сэлбэ төв дэд төв чинь одоо уг нь 30 хувийн гүйцэтгэлтэй, энэ жил уг нь 60 хувьд нь хүргэх ийм төлөвлөгөөтэй явж байсан. ААН байгууллагууд өөрсдийн хөрөнгөөр ажлуудаа явуулж байсан. Энэ хууль батлагдвал ажлын хөлсөө авчихна даа гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байсан юм байна лээ шүү дээ. Одоо тэгээд ажлаа хаяна, жагсана барина л гэсэн юм сонсогдож байна лээ. Тэгээд ажил гүйцэтгэж байгаа байгууллагуудынх нь 70 хувь нь дотоодын ААНБ юм байна лээ шүү дээ. Тэгээд авсан зээл, босгосон бондоо

ашиглаж чадахгүй, тэгээд ийм попролтын улмаас ажлыг нь зогсоохлоор эдийн засаг чинь улам л ингээд боомилогдоно шүү дээ. Ядаж энэ хувийн хэвшил ажлын байраар хангаад үйл ажиллагаагаа явуулж байвал уул нь сайн л баймаар юм.

Б.Жавхлан: Асуулт асуух гишүүдийн жагсаалтад Лодойсамбуу гишүүнийг нэмье. Хариулт 5 номерын микрофон, Жадамбын Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Монгол Улсын эдийн засаг дефолт зарлах ийм түвшин болоогүй, тийм нөхцөл байдал ч үүсээгүй. Ингэж хамаагүй ярьж болохгүй байх гэж бодож байна. Төсвийн тусгай шаардлага гэж байгаа. Төсвийн тусгай шаардлагад нийцүүлээд энэ төсвийн хүрээ, төсөв орж ирж байгаа. Ер нь энэ Төсвийн тогтвортой байдлын хууль гэдэг энэ төсвийн сахилга батыг сайжруулах, бодлогын хэрэгжилт тасралтгүй улс төрөөс ангид байх бололцоог л хангаж байгаа их гол хууль шүү дээ. Мэдээж боловсронгуй болгох асуудал байгаа. Энэ дээр Лувсандорж гишүүн ахлаад, ялангуяа цаглавартай холбоотой өөрчлөлтүүдийг хийх үүднээс ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ тун удахгүй өргөн барихад бэлэн болж байгаа.

Гадаад зээлийн ашиглалт одоогийн байдлаар дотоодын бүтээгдэхүүний 39 орчим хувьтай байгаа. Бид 27, 28 онуудад 50 хувь, 29 оноос 45 хувь байхаар ингэж буулгах хэмжээнд байгаа. Өрийн дээд хэмжээг эдийн засгийн нөхцөл байдал болон гадаад зээлийн ашиглалттай уялдуулаад ингэж тооцож, зохистой харьцаагаа авч яваа. ЗГ-ын өртэй холбоотой асуудал байна. ЗГ-ын өрийн хэмжээ 2025 оны байдлаар 35,4 их наяд буюу ДНБ-ий 39 хувьтай байна. Тэгэхээр гадаад зээлийн ашиглалттай холбоотой сая Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хууль Их Хурал дээр дэмжлэг аваагүйтэй холбоотойгоор ЗГ өнөөдрийн хуралдаанаараа энэ асуудлыг хэлэлцээд, хуулийн төслийг нэн яаралтай горимоор УИХ-д өргөн барихаар өгч, өргөн барихаар бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ хүрээнд 2 төсөл буюу Алтан ширээн нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэний УЦС-ын төслийг оруулж ирж байгаа.

Б.Жавхлан: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Дефолт зарлах хэмжээнд хүрэх вий гэснийг та ойлгож байгаа байлгүй дээ. Ер нь нөхцөл байдал маш хүнд болчихсон байгаа гэдгийг зүгээр хаалттай ч гэсэн хамаагүй танилцуулж хэлээч гэж би хүсээд байгаа байхгүй. Би нээлттэй хүмүүст ярь, попор гэж хэлээгүй шүү дээ. Нөхцөл байдал чинь хүнд байгаа гэдгийг тоо харуулаад байгаа байхгүй юу. Занданшатар дарга чинь тоо худал хэлдэггүй гээд зөндөө л ярьсан шүү дээ. Тоо худал хэлдэггүй, төсвийн орлого чинь эхний 4 сарын байдлаар 1,4 их наядаар тасарчихсан байгаад байгаа шүү дээ. Тэгээд энийгээ л яриач. Энэ орж ирж байгаа хуулийн төслүүдтэй чинь холбоотойгоор хэлэлцэж эхлэхээс нь өмнө энэ гишүүдэд бодит мэдээлэл өгөөч л гээд байгаа байхгүй юу.

Энэ татварын хуулиуд ч тэр, бусад энэ цалин хөлсний асуудал ч тэр бүхий л асуудлууд чинь урсгал зардлыг нэмэгдүүлэх хуулийн төслүүд яваад байна шүү дээ. Тэгээд гишүүд чинь мэдээлэлгүй байгаа учраас буруу шийдвэр гарах гээд байна, иргэд, олон нийт ч гэсэн мэдэх хэрэгтэй. Тусгайлсан нэг тийм бодлого зоригтойнхон шиг гаргаж нэг юу байдаг юм, нэг ирэх, мэдэхгүй та нар яах ёстой юм. Энийгээ нэг, нэг л их хөөсрөөд л нэг хий яваад байна даа. Нэг л болохгүй байгаа гэдгийг чинь уг нь би ингээд мэдээд, тоо чинь худлаа ярихгүй байгаад байна шүү дээ. Тэгээд л мэргэжлийн яамныхан бүгдээрээ л чимээгүй ёстой яана даа гээд л сууж байгаа шүү

дээ. Тэгээд энийгээ энэ шийдвэр гаргаж байгаа хүмүүстээ мэдүүлээд өгчих л дөө. ЗГ-ыг муу ажлаа хийж байна гэж хэлэх гээгүй шүү дээ. Зүгээр ингээд нэг хамтдаа зөв шийдвэрүүдийг гаргамаар байна шүү дээ.

Б.Жавхлан: Ариунзаяа гишүүний асуулт төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуугаад байна шүү. Одоо байгаа санхүүжилт чинь ямар явж байгаа юм бэ гээд. Уг нь Сангийн яамнаас хариулбал их зүгээр дээ. Тэр орлогын бүрдүүлэлт чинь ямар байгаа юм, энэнтэй холбоотой төлөвлөгдсөн төсвийн хуваарийн дагуу санхүүжилтүүд чинь гарч байгаа юм уу, үгүй юм уу? Сарын өмнө л уг нь хэвийн явж байсан, одоо сарын дотор тэгж айхтар хүндэрчихсэн зүйл байгаа юм уу. Энийгээ нэг мэдээллээ зөв өгөхгүй бол ийм байдлаар олон нийтэд мэдээлэл өгөх их хортой шүү. Уг нь Сангийн яамнаас л хариулбал зүгээр дээ. Ажлын хэсгээс 5 номер, Тэргүүн шадар сайд Жадамбын Энхбаяр, дараа нь 8 номер Санжаадорж Сангийн яамнаас.

Ж.Энхбаяр: Дефолт гэдэг маань ер төлбөрөө төлж чадахаа болиод ирж байгаа үеийн асуудал. Монгол Улсын ЗГ бүхий л гадаад зээл өрөө цаг хугацаанд нь, хугацаа хоцрохгүй шийдэж явж байгаа. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын санхүүгийн байгууллагууд тогтвортой нэмэхээр үнэлж байгаа. Төсвийн орлого ноднингийн мөн үеэсээ 14 хувиар илүү явж байгаа. Орлого тогтвортой ордог орлогоо л олж байгаа. Энэ дотроо онцгой нэг зүйл экспорт сайн байгаа. Ноднингийн мөн үетэй харьцуулахад 2,2 тэрбум долларын экспорт бид илүү хийгээд, үндсэндээ нүүрс, зэс, төмөр гээд 60 хувь нэмэгдчихсэн явж байна. Бидний гол өнөөдрийн шийдэх ёстой асуудал юу үүсэж байгаа 2 асуудал байна. 1 дүгээрт урсгал зардлын нэмэгдэл буюу багш, эмч, эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтан албан хаагчид, тэтгэврийн нэмэгдэл өөрөө төсөвт 27 онд 4 их наяд төгрөгийн нэмэлт зардал үүсгэж байгаа юм.

Гэтэл нөгөө талдаа энийг нөхөх хэмжээний орлого чинь хөрөнгө оруулалтаа хасаж байж, шинэ хөрөнгө оруулалт хийхгүй нөхцөл байдал үүссэн гэдэг асуудал байхгүй юу. 27 онд шинээр хөрөнгө оруулалт хийх бололцоо байхгүй. Хуучин үргэлжилж байгаа 3,6 их наядын хөрөнгө оруулалтаас 2,2-ыг л санхүүжүүлэх хэмжээнд л юу гарч байна. Нэгэнт урсгал зардал, цалин тэтгэвэр, энэ тэтгэмжийн нэмэгдэл буцах аргагүй. Нэгэнт ингээд нэмсэн бол ингээд үлдчихэж байгаа. Тэгэхээр урсгал зардал маань ингээд нэмчхэж байгаа, эрс нэмчхэж байгаа асуудал байхгүй юу даа. Орлогоосоо давсан эрс нэмэгдэл хийсэн. Нөгөө талаар одоогийн гүйцэтгэл бол, тэн дээрээ Сангийн яам хариулаад яваг. 2 дугаарт эрсдэл нь инфляц буюу энэ дэлхий нийтэд учраад байгаа, өнөөдөр яг энэ дэлхийн эрчим хүчний томоохон хямралт байдал үүсэж байна шүү дээ. Эрчим хүч дээр дагасан инфляцын.../минут дуусав/

Б.Жавхлан: Ажлын хэсгийн 5 номер гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: 2 дахь эрсдэл нь манайд үүсээд байгаа, төсөвт үүсэж байгаа эрсдэл нь инфляц. Шатахууны үнийн инфляцтай холбоотойгоор инфляц өнөөдөр 4 сарын байдлаар 2 оронтой тоо буюу 10,1 хувиар гараад эхэлж байна. Үүн дотроо хүнсний инфляц 14 хувьтай гарч байна. Тэгэхээрээ бид хариу арга хэмжээнүүдийг ЗГ тодорхойлоод, хариу арга хэмжээнүүдийг аваад явж байна. Шатахууны нефть бүтээгдэхүүний тогтвортой байдлыг бүрэн хангаж байна. Инфляц дотроо хүнсний инфляц, мах, хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүн инфляцад гол хувь эзэлж байна. Энэ нь манай дотоодоосоо бид өөрсдөө шийдэх бололцоотой, бууруулах бололцоотой инфляц гэж үзэж байгаа тул энэ хаврын тариалалт дээр бид өвлийн

нөөц шатахуунаараа 10 мянган тонн түлшийг хөнгөлөлттэй буюу үнэ нэмэгдээгүй үнээр нийлүүлж байна. Мөн татаад нөөцөлчихсөн байсан ургамал хамгааллын бодис, бордоог нийлүүлж байна. Тэгэхээр энэ жилийн хаврын энэ төмс, хүнсний ногоо, үр тарианы тариалалт бол.../минут дуусав/

Б.Жавхлан: Ажлын хэсгийн 8 номер, Сангийн яам, Төсвийн бодлогын газрын дарга Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төлбөр тооцоо гүйцэтгэх манай төрийн сангийн чадвар хэвийн байгаа. Маш энгийнээр тайлбарлавал манай төсвийн бүтэц маань өөрөө нийт урсгал зардлын маань 80 гаруй хувь нь тогтмол зардлууд байгаад байдаг. Өөрөөр хэлбэл цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, халамж, дээрээс нь зээлийн хүүгийн төлбөрүүд байдаг. Энэ зардлууд маань жигд 12 сард ингээд хуваарилагдаад зарцуулах ёстой байсан гэсэн үг. Гэхдээ нөгөө талдаа манай орлого маань улирлын чанартай. Өөрөөр хэлбэл барилгын улирал эхлэх буюу 4, 5 сараас манай орлого нэмэгдэж явдаг, эхний саруудад бага байдаг. Жил болгоны 1 дүгээр улиралд угаасаа орлого маань, зарлага маань орлогоосоо давчихсан байдалтайгаар байдаг. Одоо алдагдал 1,4 их наяд байгаагаас орлогын төлөвлөгөө тасарсан 1,4 их наяд биш шүү. Тэр бол 800-аас 900 тэрбум орчим дээр байж байгаа төлөвлөгөөнөөс. Одоо бидний хувьд энэ дээр асуудалгүй явж байгаа.

Нөгөө талдаа дефолт гэдэг тийм эрсдэл Монгол Улсад байхгүй. Дефолт гэдэг өөрөө гадаад улсад төлж чадах, төлөх ёстой амлалтаа биелүүлж чадахгүй байх энэ эрсдэлийг хэлж байгаа. Тэрнээс биш Их Хурлаар баталчихсан алдагдлаа бид бариад, яг үүнийх нь дагуу зарлага, санхүүжилтээ санхүүжүүлээд явахад болно гэдэг зүйл байгаа. Гэхдээ сая Эдийн засгийн хөгжлийн сайдын хэлсэнтэй яг ижилхэн оны эцсээр бидэнд нэмэлт санхүүгийн ачаалал үүсэх эрсдэл гарч магадгүй гэдэг ийм агуулга харагдаж байна. Мөн орлого дээр оны эцсээр бид хэр зэрэг гүйцэтгэл хангалттай байх вэ гэдгээс эрсдэлийн асуудал харагдахаар байгаа. Мөн зарлага дээр нэмж хэлэхэд оны эхэнд энэ оны 1 дүгээр улиралд ноднингийн 2025 онд бага хэмжээний өр төлбөр гарсан байгаа. Тодорхой хэлбэл хөрөнгө оруулалт дээр 260 гаруй тэрбум, урсгал зардал дээр мөн хэмжээний өр төлбөр хувийн хэвшлийн байгууллагуудад өгөх өр төлбөрүүд гарсан байгаа. Энийг бүрэн санхүүжүүлж дуусгасан байгаа 1 дүгээр улиралд. Тийм учраас зарлага жаахан өндөр байсан.

Б.Жавхлан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Би л нэг дефолт гэдэг юмыг мэдэхгүй байв гэж дээ, аягүй хэцүү. Гадаад зээл төлөх хугацаан дээр чинь тэгээд бид өөрсдөө төлөх мөнгөтэй байх уу, үгүй юу гэдэг чинь тэгээд л тухайн үед нь яригдана шүү дээ. Ер нь дефолт зарлах энэ эрсдэл үүсэх вий гэдгийг л яриад байна шүү дээ. Одоо байгаа зардлаа, урсгал зардлаа ч тэр орлогоороо нөхөж чадахгүй байгаа нөхцөл байдалд байгаа шүү дээ. Тэгээд дээрээс нь баахан зээл авчихсан, бонд босгочихсон, тэрнийгээ зарцуулж чадахгүй. Яагаад гэвэл Төсвийн тогтвортой байдлын хуулиар өөрсдийгөө чөдөрлөчихсөн хязгаарлачихсан. Энийг чинь л би яриад байгаа шүү дээ. Тэгээд одоо энэ хэлэлцэхээр зөвшөөрсөн энэ хуулиудыгаа хар л даа, ЗГ ч гэсэн өөрийнхөө энэ татварын хуулиа харахгүй юу даа.

Төсвийн орлогоо нэмэгдүүлээд байгаа хуулиуд юм уу, бууруулаад байгаа хуулиуд юм уу, урсгал зардлаа нэмээд байгаа юм уу, бууруулаад байгаа юм уу?

Энийг чинь л би яриад байгаа шүү дээ. Хүний ойлгомжтой хэлээр яриад байхад намайг тэнэг юм шиг нэг сонин хариулт хэлээд байх юм. Зөв нөхцөл байдлаа үнэлээд дүгнээд, зөв хуулиудаа явуулъя л гэж байгаа шүү дээ. Та нарын хариултаар бол бүх юм сайхан байгаа юм байна, окэй тэгвэл энэ бүх хуулиуд чинь тэгээд яваг. Тэгээд ирэх жил яах вэ гэдгийгээ тэгээд бүгдээрээ уйлаад суух уу, эсвэл дараа дараагийн бидний хүүхдүүд тэгээд төлөөд бүх юм нь болоод явах уу? Би тэрийг л хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд би хариултад чинь бухимдаж байна, би нөхцөл байдалд бухимдсан юм биш. Тэгээд энэ 9 тоогоо хар даа. Ирэх жил тэгээд инфляц 7 хувьтай байлаа юу энэ хуулиудтайгаа. Би хариулт хүсэхгүй байна, больё.

Б.Жавхлан: Ариунзаяа гишүүний тэр дефолттой холбоотой асуугаад байгаа нь уг нь ЗГ-ыг дэмжиж асуугаад байна гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэр чинь ингэж асуугаад байна шүү дээ наад гадаад зээлийн ашиглалт ингээд саяын хууль чинь батлагдаагүйгээс болоод аль хэдийн нөгөө тоолуур нь эхэлчихсэн 2 том зээл чинь ингээд ашиглаж чадахгүй 4, 5 жил, бараг 10 жил ингээд сунжирвал энэ зээлээ эргэж төлж чадахгүй, эндээс чинь үүсэж ийм дефолт гэж яригдаж байгаа байхгүй юу. Тэрнээс биш өнөөдрөөс энэ төсвийн тэр алдагдалтай холбож яриагүй байна шүү дээ. Тийм хариулт хүсээгүй. Дараагийн гишүүн Доржзовдын Энхтуяа гишүүн асуултаа асууя. Уучлаарай, Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ тэр гадаад зээллэг бол УИХ дээрээс буцчихсан гээд энэ Засгийн газрын гишүүд юм яриад байх юм. Өчнөөн сайд нь тэр танхимд байгаагүй шүү дээ, 64 хүрэхэд 3 гишүүн л дутсан, танай ЗГ-ын 3 сайд ороод ирчихсэн бол энэ хууль батлагдаад л явах байсан. Одоо ингээд нэг Улсын Их Хурлын буруу юм шиг юм яриад байх юм. Тэр үнэнээр нь хэл л дээ, сайд нар нь өөрсдөө орж ирээд хуулиа батлахад суу, Байнгын хорооныхоо хурал цуглаан дээр суу. Өнөөдөр сайд нарыг чинь хүлээж цаг гаран суулаа шүү дээ бид энэ Байнгын хороон дээр. Тэгээд энэ зарим нэг зүйл дээр энэ УИХ руу ЗГ үндэслэлгүйгээр УИХ-аас болчихсон юм шиг хэлэхээ болимоор байна. Сайд нар байгаагүй гэдгийг ярианы эхэнд хэлье.

Энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор энэ хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 27 онд 7 хувь, 28 онд 6, 29 онд 5 гэнэ. Дөнгөж сая Энхбаяр сайд маань ярьж байна шүү дээ. Энэ хүнсний бүтээгдэхүүн дээр инфляц 14 хүрчихлээ. Энэ бараг 14-өөс давах байх энэ махны үнийн царайг харахад. Тэгээд энэ инфляц их чухал болчихоод байна, яагаад ингээд төсөөлөөд байна гээд асуух гээд байгаа юм. Яагаад гэвэл бид тэтгэвэр, тэтгэмжээ 1 сарын 1-ний дотор инфляцтай уялдуулж нэмдэг хуультай улс. Өнөөдөр нэг тэтгэвэр, тэтгэмжийн асуудал ярихаар нэг хэдэн ахмадуудын тэтгэврийн асуудал юм шиг хандаад байна л даа. Гэтэл яг үнэндээ тэр чинь банкин дээр очоод, тэтгэврээ аваад, өөртөө зориулаад нэг сайхан хувцас өмсөөд, сайхан хоол иддэг ахмад гэж ер нь байхгүй шүү дээ манай Монгол Улсад. Монгол орон даяараа суманд, аймагт тэр ахмадын зээлээр чинь, ахмадын зээлээр чинь л амьдарч байна ахмадын тэтгэврийн зээлээр. Тэтгэврийн зээл машины урьдчилгаа болж байна, тэтгэврийн зээл цалингийн зээл хааж байна, тэтгэврийн зээл цагаан сар хийж байна, тэтгэврийн зээл өрхийн бүх амьжиргаа болж байна.

Өөрөөр хэлбэл Монгол орон даяараа тэр тэтгэврийг чинь хэрэглэж бүгдээрээ амьдарч байна. Ахмадууд сургууль, цэцэрлэгт хүүхэд зөөгөөд, гэр орны ажил хийгээд, дээрээс нь тэтгэврээр үр хүүхдээ, орон нутагт байгаа иргэдэд нэмэр тус болж амьдарч байна. Ийм учраас тэтгэвэр бол бүх нийтийн асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр ирэх жил энэ тэтгэврээ ер нь яаж нэмнэ гэж тооцоолж байгаа юм бэ? Саяын оны өмнө хуурдаг шиг 80, 80 мянган төгрөг нэмээд орхих юм уу, орон

зайг нь яаж төсөөлж байгаа юм бэ? Одоо энэ 14 хувь болчихоод байгаа инфляцтай чинь уялдах юм уу энэ? Тэгээд бодитойгоороо наад инфляц чинь бүүр дээшээ өсөөд явбал бидэнд яг энэ орон зайдаа энэ тэтгэврээ нэмэх мөнгө байгаа юм уу? Ер нь ахмадынхаа төлөө ямар нэг зүйл хийх юм уу? Гадаа ингээд бүтэн 9 сард намрын чуулган эхэлснээс хойш ордны баруун хаалган дээр хөгшчүүл ингээд л хоолойгоо сөөтөл орилоод байж байна. Ахмадуудын маань чих нь жоохон хатуу байна, Монгол төрийн чих бүүр хатуурчхаж, хариу өгөх хүн алга. Нэг хэдэн юм орилж л байдаг гэсэн юм шиг байна. Тэгээд энэ асуултууддаа хариу авъя.

Б.Жавхлан: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, Эдийн засгийн хөгжлийн сайд, Шадар сайд Жадамбын Энхбаяр.

Ж.Энхбаяр: 25 оны төгсгөл инфляц 7,5 хувь буюу зорилтот түвшнээ хангасан, 4 дүгээр сарын байдлаар 10,1 хувь. Үүний учир шалтгаан хүнс, хүнс дотроо махны өсөлт, нөгөө талдаа шатахууны өсөлттэй холбоотойгоор ийм нөлөөлөл мэдрэгдэж эхэлж байна. Энэ инфляц ганц Монголын асуудал дэлхий нийтийн асуудал болоод, эрчим хүч дагасан нэлээн хүндрэлүүдийг улс орон болгонд бий болгож байна. Хариу арга хэмжээнүүд улс орон болгон янз янзаар авч хэрэгжүүлж байна. ЗГ 1 дүгээрт шатахууны байнгын тасралтгүй байдлыг хангаж байгаа, үнийн гэрээнүүд хийгдсэн, тогтвортой байдал хангагдаж байгаа. Мах, гурил, ногоог бид дотоодоосоо хангах бололцоотой талд нь бид нэлээн дэмжлэг үзүүллээ. Энэ жил үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт, энэ жилийн өвөлжилт эвтэйхэн, малын төл авалт боломжийн. Тэгэхээр махны нийлүүлэлт удахгүй ингээд мал ногоонд цадаад ирэхээр нийлүүлэлт нэмэгдээд, дотоод хэрэглээгээ нь хангачих байх. Тэгэхээрээ ийм үндсэн дээрээс инфляцын хүлээлт буурна гэсэн хүлээлттэй байна гэсэн үг. Гол өсөлт байгаа мах, ногоо буураад ирэхээр инфляц буурна.

Инфляцаа бид төсвийн хүрээндээ инфляцын өсөлтийг тэтгэвэр дээр 8-аас 10 хувьд тооцож хүрээг нь гаргаж өгсөн. Яг энэ гүйцэтгэлээрээ хуульд нийцүүлээд ахмадын тэтгэвэр нэмэгдэнэ. Хамгийн багадаа 8 хувь буюу Монголбанкны зорилтот түвшин, тэгээд эрсдэлээ тооцоод 10 хүртэл инфляцаа 2 оронтой тоонд хүрлээ гээд бодоход 10 хувийн өсөлт гээд, энийгээ төсвийн хүрээгээрээ урсгал зардал дээрээ гаргаад тооцоод оруулаад өгсөн байгаа. Намар гэхэд нэлээн төсөв өргөн барихад нарийн задаргаатай тодорхой болоод ороод ирнэ.

Б.Жавхлан: Санжаадорж дарга тэр жилийн дундуур төсвийн алдагдал гээд хэн, хаана тийм юм ярьчихсан юм бэ, тийм ойлголт байхгүй шүү дээ. Тэрийгээ нэг зөв тайлбарла л даа. Төсвийн алдагдал гэдэг чинь жилийн эцэст ганц удаа гардаг л гүйцэтгэл болохоос биш, жилийн дундуур орлого бүрдүүлэлт, нөгөө талдаа наад төсвийн хуваарь чинь хуваарийнхаа дагуу л зардал явж байгаа. Тэр зөрөө чинь төрийн сан дээрээ л ачаалал болж очдог болохоос биш, энэ чинь алдагдал биш байхгүй юу. Тэгээд тэрийгээ зөв тайлбарла л даа. Тэгээд тэгэхгүй ингээд буруу мэдээллээ өгөөд, нэг алдагдалд орчихсон юм шиг ингээд жил болгон л нэг ийм юм яваад байдаг. 8 номер тэрэн дээр нэмэлт тайлбар өгөх үү? 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. УИХ-аас төсвийн хүрээний мэдэгдэл дээр тухайн жилийн алдагдлыг баталдаг байгаа. Тухайн жилийн нийт орлого бүтэн жилийн турш нийт орлого, бүтэн жилийн турш нийт зарлагын асуудал явдаг. Сар болгоны хувьд орлого, зарлагын зөрөө өөрөө мөнгөн хөрөнгийн менежмент буюу cash flow-нхоо хүрээнд явагдаад явдаг байгаа. Манай улсын хувьд улирлын чанартай орлогын

бүрдэлтэй уялдуулаад энэ орлого маань ингээд ихсэж, багасаад явдаг. Зарлага маань харьцангуй тогтвортой байдлаар ингээд явдаг. Жилийн эцэстээ бид энэ алдагдлаа бариад явдаг. Сангийн яамны хувьд алдагдлаа бол алдаж байсан тохиолдол байхгүй. Жилийн эцсээр ямар ч тохиолдолд энийгээ ингээд бариад гараад явах ийм л зүйлтэй байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа. Уучлаарай, Оюунсайханы Алтангэрэл гишүүн тодруулъя.

О.Алтангэрэл: Ер нь Энхбаяр сайдын хэлж байгааг ойлгож байгаа, ер нь бүх юм тулчхаад байна гэж хэлж байгаа шүү дээ. Тэгээд одоо бидэнд нөөц байна уу гэвэл байгаа байхгүй юу. Түрүүхэн бид Байнгын хорооны хуралдаан дээр энэ хаврын чуулганы хэлэлцэх асуудлын тов дараалалд оруулаагүй нэлээн хэдэн хуулийг орууллаа. Тэгээд даанч энэ Улсын Их Хурлын даргаас асуудаг дэг алга. 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын ЗГ-аас Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг өргөн барьсан юм. Ирэх долоо хоногт нэг жилийн ой болох гэж байгаа юм. Би бол юунд итгэлтэй байгаа вэ гэхлээр ингээд л ахмадын тэтгэвэр ч ярьсан, нийгмийн ямар ч асуудал ярьсан, цалин нэмэх асуудал ярьсан ч бид ингээд ийм төсвийн хүндрэл, мөнгөний зовлонтой нүүр тулж байгаа юм. Үгүй ээ тэгээд энэ өнгөрсөн 10 жилийн турш хяналтгүйгээр хулгайлсан энэ хулгайчуудынхаа хөрөнгийг хураая л даа. Хуулийн төслийг нь ЗГ-аас өргөн мэдүүлчхээд жил болж байна шүү дээ. Хэлэлцэх асуудлын дараалалд ороогүй хуулиудыг бид батлаад байдаг, оруулъя гээд байдаг.

Гэтэл аль хэзээний намрын чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд байсан, энэ хаврын чуулганы хэлэлцэх асуудлын дарааллын 9-д байгаа уг нь дэг байдаг бол би энэ Бямбацогт даргаас асуумаар байгаа юм. Яагаад энийг ингээд хэлэлцүүлэхгүй удаад байгаа юм бэ? Өнөөдөр яг энэ ажил хийж байгаа, яаж мөнгө олж энэ төсөвт мөнгө илүү оруулъя гэж явж байгаа, энэ ажил хийж явж байгаа хүмүүст л хэрэгцээтэй мөнгө тэндээс гарна шүү дээ. Тэр ахмадуудынхаа тэтгэврийг, төрийн албан хаагчдынхаа цалинг, бусад нийгмийн салбаруудаа дэмжих, тэр яриад байгаа татварын хөнгөлөлтүүдээ хэрэгжих боломж бололцоо энэ авлигачин хулгайчуудынхаа хөрөнгийг хурааж гарна. Тэгээд би дэг байхгүйг ойлгож байна. Тийм учраас би энэ тодруулах хугацаан дээрээ ашиглаж зориуд би энэ Улсын Их Хурлын дарга Бямбацогт даргад хандаж, нэгэнт хэлэлцэх асуудлын дараалалд орчихсон энэ хуулийг даруй хэлэлцүүлж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Гишүүн үг хэллээ. Ажлын албанаас гишүүний Их Хурлын даргад хандаж хэлсэн мэдээллийг уламжлаарай. Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа асуултаа асууя.

Д.Энхтуяа: Бидэнд өгсөн энэ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28 оны 28-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл гээд ЗГ-аас өргөн барьсан энэ төслийн үг, өгүүлбэр, тоо болгон үнэнд нийцэж байгаа гэдэгт итгэж байна. Тийм учраас нэг асуулт байна. Ингээд энэ номын 40 дүгээр хуудсан дээр сүүлийн сүүлийн 10 жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар орлого дунджаар 28,7 хувь, харин сүүлийн 5 жилд дунджаар 35,9 хувиар өссөн байна гэсэн ийм мэдээлэл байна. Дунд хугацаанд ААНОАТ-ын өсөлтийг ойролцоогоор 10 хувьд хадгална гэж ингэж төсөөлсөн байна. Энэ нь болохоороо мэдээжийн хэрэг дэд бүтцийг сайжруулж, хил холболтын ажлыг дуусгаснаар түүхий эдийн экспортын биет хэмжээ нэмэгдэхээр байна.

Түүнчлэн нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсний экспортод эзлэх баяжуулах коксжих нүүрсний хувь хэмжээ өснө гэсэн байна. Энэ дээр мөн Оюу толгой /ОТ/-н экспортолж байгаа зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдсэнээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/-ын орлогод эерэг нөлөө үзүүлэхээр байна гэсэн ийм өгүүлбэр байгаа байхгүй юу. Тэгээд эндээс үүдээд энэ ОТ хэзээнээс эхлээд ААНОАТ-ыг төлдөг болчихсон юм бэ? Тэгээд яг ААНОАТ төлдөг болсноор энэ 10 хувь хадгалагдана, дээрээс нь өснө гэж байна шүү дээ. Тэгэхээр яг энэ ААН-ийн орлогын татварыг яг хэдэн хувиар өсгөж байгаа юм бэ? Хэзээнээс эхэлж яг энэ орлогын албан, ААНОАТ-ыг төлдөг болчихсон юм бэ? Энийг би Сангийн яамнаас асууж байна.

2 дахь асуулт нь сая Алтангэрэл гишүүнтэй би санал нэг байна. Энэ гадаа жагсаад байгаа ахмадууддаа бид эмэгтэй гишүүд ер нь нэг нэгээрээ л гарч уулзсан. Би уулзаад нэлээн олон ахмадуудтай их танил болсон, 2 ч ахмадын гэрээр нь очсон. Үнэхээр энэ хүмүүс сэтгэл зүрхээрээ ингээд бүтэн жил жагсчихлаа л даа. Тэгээд гэрт нь очоод ингээд нэг аяга цайны сүү бариад ингээд очиход үнэхээр амьдрал маш хүнд ахмадууд энэ гадаа зогсоод байна. Ахмадуудын чинь бараг 90 хувь нь энэ 700 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмж авч байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ нэг шинэ реформ хийхгүй юм уу энэ тэтгэврийнхээ энэ бодолт дээр?

ЗГ-аас энэ Баялгийн сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах уу? Бид өнөөдөр газрын доорх баялаг ард түмний өмч хөрөнгө мөн, ард түмэн адилхан энийг эдэлж хэрэглэх эрхтэй гэгчхээд энэ ахмадууддаа бид үнэхээр энэ баялгийн хуваарилалтыг хуваарилж чадахгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ Баялгийн сангийн хуульд өөрчлөлт оруулаад, бид тэр Ирээдүй өв санд цугларч байгаа энэ их уул уурхайгаас орж ирсэн ашгийг бид нэг гадаадын банканд З-аас 5 хувийн хүүтэй ингээд 30 жилээр түгжээд ингээд байх юм уу, эсвэл энэ өнөөдрийн нөхцөл байдал тохируулж энэндээ энэ хуульдаа өөрчлөлт оруулах юм уу? ЗГ энэ дээр ямар бодолтой байдаг юм бэ? Тэр Хөгжлийн санд орсон энэ.../минут дуусав/

Б.Жавхлан: Ажлын хэсэг Сангийн яамнаас асуусан. 8 номер Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. ОТ суутган татвар бол төлж байгаа гадагш шилжүүлсэн орлогоосоо суутганаа төлж байгаа гэсэн үг. Шууд яг ААНОАТ-ын байдлаар одоогоор төлөхгүй байгаад байна.

Б.Жавхлан: Энхбаяр сайд нэмж хариулъя, ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Баялгийн сангийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар ажлын хэсэг гарчихсан, Хэрэг эрхлэх газрын сайд Б.Энхбаяр ахлаад явж байгаа. Энэ хаврын чуулгандаа багтаж өргөн барихаар ингээд ЗГ-аас үүрэг өгсөн ажиллаж байгаа. Тэр ерөнхий эдийн засгийн өсөлт ирэх онуудын энэ төсөөлөл ер нь нэлээн л статистик, Монголбанк, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, гол томоохон экспортлогч, импортлогч, татвар төлөгч, Монгол Улсад хийгдэж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалт маш олон үзүүлэлтийг аваад энэ ерөнхий төсөөлөл гарч байгаа. Сүүлийн 4 жилийн байдлаар харахад энэ таамагласан эдийн засгийн өсөлт, инфляц, ер нь бодлогууд энэ төсөөллүүд ер нь яг байндаа тусаад, ер нь тун ойрхон гараад байгаа. Тэгэхээр манай ер нь энэ төсөөлөл, энэ тооцоолол хийх

боломж чадавх яг л олон улсын арга стандартчиллын дагуу тэгээд энэ нийцэлтэй гарч байгаа.

Ирэх онуудад нэлээн томоохон ажлууд явна. Хил холболтын төмөр замууд холбогдоно, дагаад нүүрсний экспорт, олборлолт нэмэгдэнэ. Манай гол экспорт болсон нүүрс, зэсийн үнийн төлөв байдал зах зээл идэвхтэй байж байна. Төмрийн үнэ боломжийн, нийлүүлэлт экспорт нэмэгдэхээр байж байна. Тэгээд боловсруулах үйлдвэрүүд ган, зэсийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих томоохон бодлогын ажлууд эхлэх нь байна. Хүнсний хувьсгал, Атар, Цагаан алт хөтөлбөрүүд үргэлжилнэ. Энэний нөлөө цааш хадгалагдана. Энийг улам дэмжиж, Евразийн орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр гадаад зах зээл нь идэвхжүүлэх ажлууд явагдана. Баян, Бөөрөлжүүт, ТЭЦ 5, Дарханы нөгөө Тавантолгойн цахилгаан станц гэсэн томоохон эрчим хүчний төслүүд, сэргээгдэхийн томоохон төслүүд үргэлжлэхээр хийгдэхээр болж байгаа. Энийгээ дагасан барилга угсралтын Алтан Ширээ, Эрдэнэбүрэний томоохон төслүүдийн барилга, угсралтын ажлууд нэлээн идэвхтэй явагдана. Тэгэхээр энэ өсөлтийнхөө энэ зорилтот энэ хувиа бид.../минут дуусав/

Б.Жавхлан: Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: ЗГ, Сангийн яам тэгэхээр Их Хурлын гишүүдэд УИХ-д энэ худал мэдээллийг ингэж оруулж ирэх хэрэггүй гэж би бодож байна. Тэгэхээр яг үнэн, яг ААНОАТ би төлдөг болчихсон юм байх гэж яг бодсон байхгүй юу. Яг энэ дээр ингэж бичсэн байна. Тэгэхээр төлдөггүй юмыг төлдөг гэж УИХ-д ийм худал мэдээлэл дахиж битгий оруулж ирээрэй гэж ингэж хэлье.

Дээрээс нь тэр Баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулна. Яг энэ дээр тэр гадаадын банканд бага хүүтэй хадгалуулаад байгаа энэ баялгаа ард түмэндээ, ялангуяа боловсролын салбарт, эрүүл мэндийн салбарт, ахмад настны тэтгэвэр тэтгэмж гээд энэндээ зарцуулахгүй юм уу? Энэ асуудлаа хурдан оруулж ирэхийг би шаардаж байна.

Б.Жавхлан: Ажлын хэсгийн 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энхтуяа гишүүнээ энэ худал мэдээ биш л дээ энэ чинь. Энэ түрүүний хэлсэн энэ идэвхжүүлэлтийн томоохон төсөл хөтөлбөрүүд, экспорт, импорт нэмэгдэлтэй холбоотойгоор нийтдээ манай ААН-ийн орлогын татвар бусад хураамж ер нь бүгд өсөлттэй дунджаар 10 хувийн өсөлттэй гарч байгаа. Тэгэхээр 26 оны эхний 1 дүгээр улирал гэхэд 25 оноосоо бид өсөлттэй л яваад байгаа юм. Олдог орлогоо бид олоод л, ААН-үүд нь төлдөг татвар дандаа нэг өсөлттэй л явж байгаа. Тэгээд тэр ерөнхий утгаараа хэлсэн гэж та ойлгоорой.

Б.Жавхлан: Энхтуяа гишүүн 2 дахь удаагаа тодруулъя.

Д.Энхтуяа: Энхбаяр сайд тэрийг ойлгоод байна. Ингээд ямар ч байсан ерөнхий дүнгээрээ нэмэгдээд байна 10 хувьдаа хадгална гээд бичээд байна шүү дээ. Яг энэ дээр чинь болохоороо ОТ-гоос олборлож байгаа энэ зэсийн баяжмал юу байдаг юм энэ бүх агуулгаараа ААНОАТ-т ОТ-н ААН-ийн орлогын албан татвар төлснөөрөө нэмэгдээд байна гээд ингээд бичсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр эндээс чинь Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал энийг чинь ОТ-д өөрчлөлт орчихсон юм байна, ААНОАТ төлдөг болчихсон юм байна гэсэн ийм ойлголтыг өгөөд байна шүү

дээ энэ бичиг дээр чинь. Тэгэхээр энийгээ битгий ингэж худлаа бичиж орж ирж бай л гэж хэлээд байна шүү дээ. УИХ-д ингэж худлаа мэдээлэл өгөх тийм эрх байхгүй шүү дээ та бүхэнд.

Б.Жавхлан: Тодруулгад Энхбаяр сайд хариулт, нэмэлт мэдээлэл өгье, 5 номер.

Ж.Энхбаяр: Яг ОТ, та тухайн ОТ-гоо яриад байна. Гэтэл ОТ-гоо дагасан олон их наядын бүтээн байгуулалт, худалдан авалт, туслан гүйцэтгэл томоохон энэ ААН-ийн орлогын татвар төлж байгаа үйл явдал байгаа шүү дээ. Тэгэхээрээ тэрийгээ дагаад энэ чинь улам л уурхайн үйл ажиллагаа, гүний олборлолт, экспорт нэмэгдэнэ. Тэрийгээ дагаад тээвэр, олборлолт, тэсэлгээ үйлчилгээ гээд хоол унднаас авхуулаад энэ нөлөөлөл яг энэ ороод байгаа байхгүй юу. Тэгэхээр та битгий яг зөвхөн ОТ гэж авч үз. Бусад үйлчилгээнд чинь дагасан зүйлүүд байгаа юм шүү, тэгээд ойлгоё, энийг нэг мушгиад, улс төржүүлэх юм биш шүү дээ.

Б.Жавхлан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуултаа асууя.

Ч.Лодойсамбуу: Ганцхан энэ цаасан дээр цагаан дээр хараар бичсэн юмаа ингээд л энд буруу байна гэхээр тэндээс зөв байна гээд л энэ бол юу ч биш юм байна лээ. Зүгээр өөдөөс хараад л худлаа яриад байдаг юм байна лээ. Ер нь ямар ч Ерөнхий сайд, Сангийн сайд байгаад нэмэргүй юм байна гэж ойлгож байгаа. Энхбаяр сайдын өчигдөр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь энэний хэрэгжих хугацааг хойшлуулах, байхгүй болгох асуудал ярьж байхдаа та тайлбар хэлж байна лээ. 500 мянган төгрөг хүртэл худалдан авалт хийвэл 100 хувь буцаан олгочихъё энэ НӨАТ-ын, тэрнээс дээш байвал 50 хувь ингээд шаталсан байдлаар буцааж олгоё гээд өөрөөр хэлбэл иргэд нь жоохон орлоготой, орлого нь жоохон нэмэгдээд өөрөөр хэлбэл бас нэг бизнес хийж байгаа хүмүүс орлоготой больё гэдэг боломжийг нь хааж байгаа юм.

Энэнийхээ шалтгааныг юу гэж тайлбарлаж байгаа вэ гэхээр төсөв 1,8 их наядар тасарна, төсөв дийлэхгүй бидний орлого хэцүүднэ гээд. Тэгээд зарлага ярихаар зарлагыг нь ярихаар өөдөөс урсгал зардал буюу багш, эмч нарын чинь, цалин тэтгэвэр чинь яах юм бэ гэдэг. Бүх л Сангийн сайд, бүх л Ерөнхий сайд нар өөдөөс ийм юм ярьдаг. Яг нөгөө кинон дээр хүүхдийг нь барьцаанд авчхаад аятайхан байхгүй бол хүүхэд чинь өвдөнө шүү гэж байгаа юм шиг. Энэ Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ барилга, байгууламжийн жагсаалт ийм зузаан. Нийт 11 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ бичсэн, 26 онд 3 их наяд зүгээр барилга барих гэж байгаа, байшин. Юуны байшин гээч иргэдэд мэдээлэл өгөх байшин. Нөгөө Оюун-Эрдэнийн барьсан Их хуралдайн нэмэлт санхүүжилт, соёл урлагийн байгууламж, Гандангийн дэнжийн зураг төсөв, Шинэ Хархорум, Бизнес инкубатор, Бяслаг цагаан идээний үйлдвэр. Бид айл юм бол орлогоо харж байгаад, зарлагаа харж байгаад үнэхээр орлого хэцүү бид байвал яадаг вэ тансаглалаа больё, зугаалгаа больё, элдэв хэрэглээгээ больё гээд хүүхдээ хоолтой байлгахыг 1 дүгээрт үздэг.

Одоо бид болохоор байшингаа барья, барилгаа барья, энд тэнд очиж тууз хайчилъя, хүмүүс мөнгөтэй байх нь яах вэ гэдэг сонголт хийж байна шүү дээ айлаар бол. Бид чинь айл юм байгаа биз дээ. Урсгал зардал нэмэгдээд байгаагийн шалтгаан нь цалин тэтгэвэр нэмэх шаардлага үүсээд байгаа шалтгаан чинь наад инфляц чинь шүү дээ, төгрөгийн ханшийн сулрал чинь. Сангийн яам, Монголбанк

энэ яг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаа нь үнэн шүү дээ. Эрхлээд байгаа юм уу Монголчууд. Цалингаа нэмүүлье гээд зүгээр хөлөө жийж суугаад байгаа юм уу, амьдралд нь хүрэхгүй байна шүү дээ та нар энийг бүүр харахгүй байгаа юм уу? Үгүй ээ тэгээд нэг жоохон илүү нэг хэдэн төгрөг, би минутаа нэмээд авчихъя. Тэгээд хэдэн төгрөг хэрэглэдэг.../минут дуусав/

Б.Жавхлан: Та нэмэлт бол байхгүй, тодруулгынхаа минутыг авах юм байна. Лодойсамбуу гишүүний тодруулах минутыг нэмье.

Ч.Лодойсамбуу: Тэгээд энийг олж харахгүй байгаа юм уу гэдэг дээр бүр гайхаад байхгүй юу. Одоо тэгэхээр та хэд өөдөөс иргэдийнхээ нуруун дээрх байгаа ачааг хөнгөлье гээд ярихаар попроод байна гээд байх юм. Би энэ үгийг бүүр гайхаад байна. Энэ зээлээс зээлд амьдардаг байсан, одоо зээл нь олдохоо больчихсон энэ үнэн шүү дээ. Одоо та хэд зүгээр захын тааралдсан хогийн саваа асгаад үз, хөмрөөд үз тэнд юу байгаа гэж хуучин янз янзын хүмүүсийн хоол хүнс, эсэн бусын чихэр жимс юм гардаг байсан бол одоо байхгүй. Хүнсний дэлгүүрүүдийн борлуулалт ямар болсон, хоолны газруудын борлуулалт ямар болсон, бид мөнгөгүй болчихоод байгаа нь үнэн байхгүй юу, амьдарч чадахгүй болчихоод байна шүү дээ. Тэгээд энийг ярихаар өөдөөс попроод байна гэж яриад байдаг.

Үгүй ээ энэ төр чинь яах гэж байдаг юм бэ, байшин барилгаа барих гэж байдаг юм уу, мэдээллийн төв барих гэж байдаг юм уу? Иргэдийнхээ амьжиргааг нь тогтвортой авч явъя, эрүүл аюулгүй амьдруулъя л гэж төр байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээр нь хийгээд өгчхөөч гэхээр өөдөөс нь тэгвэл та нарын наад тэтгэвэр чинь нэмэгдэхгүй шүү, цалин чинь хасагдана шүү гээд. Манай Сангийн яамныхан хараад одоо бодож л байгаа, мэдэж л байгаа. Хөөрхий амьтан буруу байхгүй шүү дээ, хэдэн Их Хурлын гишүүд баахан, одоо энэ яамнуудаас санал аваад сууж байгаа юм. Баахан тууз хайчлах баахан байшин, ямар нэг байдлаар нэг тууз хайчилж сонгуулийн PR хийдэг. Тэрнийхээ баахан жагсаалтыг оруулж ирээд, энийг оруулна шүү гээд шахаад суудаг, тэрийг нь хийгээд л сууж байгаа.

Тэгээд Их Хурлын гишүүддээ хэлмээр байгаа юм. Ингэж янз янзын юу ч хамаагүй юмны тууз хайчилж PR-ддаг цаг өнгөрсөн шүү дээ. Очоод тууз хайчлаад зогсохоор иргэд нь хэлнэ шүү дээ. Хөөе амьдрах аргагүй байна, чи юу хийгээд яваад байгаа юм бэ? Үнэхээр аргагүй байна шүү дээ, одоо яах юм бэ 26 оны төсөвтөө тодотгол хийгээд энэ 3 их наядын энэ газарт булах гэж байгаа мөнгөө жоохон хэмнээд, энэ иргэдээ жоохон мөнгөжүүлэхгүй юм уу. 3 их наяд, 11 их наядар төсөвлөж орж ирээд, тэгээд нөгөө нэг ЗГ нь яах вэ бас бодсон байна л даа. Өмнөх ЗГ бодож, бодож байгаад хассан байна.

Б.Жавхлан: Хариулт ажлын хэсгийн 5 номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: 26 оны батлагдсан төсөв яриад байна тийм үү? Одоо бид 27 оны төсвийн хүрээ, орлого, зарлагын гол үзүүлэлтүүдээ л ярьж байна шүү дээ. 27 онд шинээр нэг ч хөрөнгө оруулалт байхгүй, тийм төсвийн орлого байхгүй. Нийт 3,6 их наядын дамжсан хөрөнгө оруулалтууд байгаа. Энэ УИХ баталсан л хөрөнгө оруулалт шүү дээ. Үүнээс 2,2-ыг санхүүжүүлэх бололцоо байгаа. Шинээр хөрөнгө оруулалт байхгүй, урсгал зардал, цалин, тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл өндөр гарч байгаа тул энийгээ л бид санхүүжүүлнэ. Энэ санхүүжүүлэх орон зай гарахын тулд бид гадаад зээлийн ашиглалтаас том төслүүдээ гаргаад, гадаад зээлээр бусад

салбарын эрүүл мэнд, боловсрол, орон нутгийн, дэд бүтцийн, эрчим хүчний төслүүдээ явуулъя гэдэг л хуулийн төсөл өргөн барьсан шүү дээ.

Таны ярьж байгаа НӨАТ-ын асуудал бол НӨАТ-ын буцаалт нь өнөөдөр 20 хувь байгаа. Үүнийг 50 хувь болгох хууль энэ намраас хэрэгжих гэж байгаа юм. Ингээд хэрэгжсэнээр төсөвт орох орлого 1,8 их наядаар дутах нь буюу худалдан авалт хийж байгаа иргэддээ үлдэнэ гэсэн үг. 1,8 их наядын дутагдал төсөвт орлого дутаад ирэхээр нөгөө нэмэх ёстой 4 их наядын багш, эмч нарын цалин чинь хүрэлцэхээ болиод ирж байгаа юм. Тэгэхээр бидний асуудал урсгал зардлаа буюу цалин, тэтгэврийнхээ нийгмийн асуудлаа шийдэхийн тулд НӨАТ-ыг хойшлуулъя л гэж байгаа юм. Таны 500, тэр босго нөгөө НӨАТ-аас чөлөөлөгдөх хэмжээ чинь Татварын багц хууль буюу тусдаа явж байгаа хуулийн асуудал байгаа юм. Тэрийг Сангийн яам хариулаадах ийм учир шалтгаантай хууль юм гээд. Төсвийн хүрээтэй өргөн барьсан хууль НӨАТ-ын хуулийг үйлчлэлийг хойшлуулах асуудал байхгүй юу. 2 өөр юм байгаа юм шүү. Тэрийг нь та Сангийн яам тэр татварынхаа тооцоог.

Б.Жавхлан: Хэдэн номер вэ? Лодойсамбуу гишүүн нэмэлт тодруулга.

Ч.Лодойсамбуу: Яах вэ Энхбаяр сайдыг ойлгож байна, ойлгож байна. Тэгээд энэ орж ирсэн юм байна нэг юм асуудлаа нэг үүрээд гарна гээд, ямар бид анхны сайдаа харж байгаа биш дээ, тийм биз дээ. Бүгдээрээ тэгээд л нэг хариулаад гаръя гээд л боддог шүү дээ. Би зүгээр яах вэ эрүүл ухаантай хэдүүлээ нэг айл гэж өөрсдийгөө бодоод, шийдэхгүй бол, одоо та ингээд аргалаад л, танд нэг их хуурагдаад байдаг цаг өнгөрчихсөн шүү дээ хүмүүсийн хувьд. Одоо энэ чинь ингэж байна шүү дээ тоог чинь хэлж байна шүү дээ. Шинэ хөрөнгө оруулалт 27 онд байхгүй, 26 онд санхүүжүүлээд оруулж байгаа энэ 3 их наяд төгрөгөөр хийчихсэн төслүүд чинь 27 онд шинэ биш болчихно. Тийм. Тэгээд яагаад хуураад байгаа юм бэ, энэ чинь шинэ биш болчихно, энэ мөнгөө бид хэмнэж чадвал наад асуудлаа шийдэж болж байна гээд байна шүү дээ. Энэ мөнгө булж яах гээд байгаа юм бэ? Та энэ юунуудаа хар л даа, энийг харуулъя. Би танд ч биш, ер нь гишүүддээ л хэлмээр байгаа юм. Тэгж ийм юмаа одоо больчихмоор л байгаа юм.

Монгол Улсыг яг үнэндээ гишүүд нь хорлож байгаа, үнэн шүү. Энэ тойрог дээр очоод ямар нэгэн юм байгуулж, нэг тууз хайчилж, зургаа авхуулдаг. Энэ PR байхаа больчихсон. Би энд бүгдэд нь хэлмээр санагдаж байгаа юм. Яг үнэндээ авч байгаа тэтгэвэр, цалин тэр нь амьдралд нь хүрэхгүй, ажил олдохгүй байгаа үед та дэргэд нь очоод усан бассейны тууз хайчлаад зогсож байвал чулуу шидэх хэрэгтэй. Тэр мөнгөөр нь. Төсвийн орлого тасарна гээд байна шүү дээ, төсвийн орлогын төлөө бид амьдраад байгаа юм уу, сүүлдээ энэ байрлал нь бүүр ийм болчихлоо шүү дээ. Төрийг байлгахын төлөө иргэд нь ажил хийдэг, төрийг ямар нэгэн юмны тууз хайчлуулахын төлөө иргэд нь татвар төлдөг ийм болчихлоо шүү дээ. Манай Сангийн яамныхан бүгд толгой дохиж байна шүү дээ. Ядарч байгаа шүү дээ наад хүмүүс чинь. Наад хүмүүс чинь Монгол Улсдаа хайртай байгаа шүү дээ. Наад хүмүүс чинь хамаатан садан, ах дүү, нөхөдтэй шүү дээ. Бүгдийнх нь амьдрал хэцүү болж байгаа. Тэгээд ажил дээрээ ирээд хэдэн гишүүдийн шахаас түлхээсийг ингээд л ажилтай байхын тулд биелүүлээд л байж байгаа, харамсалтай байна.

Б.Жавхлан: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Яг энэ дээр тантай их санал нийлээд байна. Засаг тооцоолоод, төсвийн хүрээндээ багтааж төсвөө өргөн барьсан. Жишээлбэл, өнөөдөр одоо энэ

таны ярьж шүүмжилж байгаа төсөв дээр 2,4 их наядын 150 төсөл хөтөлбөрийг Их Хурлын гишүүд хэлэлцүүлгийн явцад нэмсэн байгаа байхгүй юу. Энэ чинь одоо үргэлжлээд ороод ирнэ. Үргэлжлээд ороод ирэхэд бид 2,8 их наядын л орон зай байна үргэлжлэх. Энэ дотор нөгөө НӨАТ-ын буцаан олголтыг хэрвээ Их Хурал дэмжихгүй бол 1,8 их наядаар энэ хөрөнгө оруулалтууд хасагдана гэсэн үг. НӨАТ талдаа 1,8 шилжээд, 2,2 чинь энэ 0, 400 болоод үлдэнэ. Гэтэл тэр 400 тэрбумын цаана чинь энэ 2,2, 3,6 их наядын санхүүжих 2,2 их наяд дээр чинь ААН-үүд зээлээ аваад, ажлаа хийгээд, гүйцэтгээд, барилга угсралт, хөрөнгө оруулалтууд явчихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар нэлээн төсвийн сахилга бат, бодлогын асуудал, хэрэгжилтийг хангах хуулиуд нэлээн нарийвчлаад ороод ирсэн. Ингээд ер нь цаашдаа Байнгын хороо хэлэлцүүлэг дээр дур зоргоор техник, эдийн засгийн үндэслэлгүй, эх үүсвэргүй, үр ашиггүй, энэ хэмжих үр дүнгийн хэмжих нэгж тодорхой бус ийм төслүүд ер нь явах бололцоо улам л багасаж байгаа. Нэг үеэ бодвол ингээд төсөв чамбайраад, бодлого чамбайраад, хууль чамбайраад ингээд цэгцэрч л байна.

Б.Жавхлан: Батхүү дарга байгаа тийм ээ, Анар дарга ТНБД, хоёр Төрийн нарийн байхгүй байгаа юм уу? Анар ТНБД байна уу? Би зүгээр хоёр ТНБД-д нь анхааруулж юм хэлэх гэсэн юм. Юуны тулд Монгол Улс Эдийн засгийн хөгжлийн яамтай болоод, одоо 5 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Эргэж ийм яамтай болсон гэсэн үг. Одоо оруулж ирж бидний хэлэлцэж байгаа энэ асуудал макро төлөвлөлтийн асуудал. Өөрөөр хэлбэл төсвийн хүрээ гэдэг маань төсвийн хүрээ гэдэг нэртэй боловч энэ 2027 оны Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал, зорилт ямар байх вэ гэдгийг хэлэлцэж байгаа.

Энэ дотор цөөхөн тоо байгаа 9, 10-хан тоо байгаа. Би 2 Төрийн нарийн бичгээс уг нь асуух гэсэн юм. Ажлуудаа хоорондоо ялгаж салгаж байгаа биз дээ гээд? Сангийн яамны ТНБД өмнө нь Сангийн яаманд байж байгаад, Эдийн засгийн хөгжлийн яаманд байгаад, тэгээд одоо буцаад Сангийн яамандаа ирж байгаа залуу байгаа. Өнөөдөр жишээ нь оруулж ирж байгаа энэ төсвийн макро тоонууд дотор орлогын доод хэмжээ гээд байж байгаа, зарлагын дээд хэмжээ гээд байж байгаа. Өөрөөр хэлбэл макро төлөвлөлт хийдэг энэ бүхэл бүтэн институц маань Сангийн яамны олж ирэх орлогыг төлөвлөж өгдөг гэсэн үг. Тэрнээс биш Сангийн яам энэ орлогыг төлөвлөдөггүй. Эдийн засгийнхаа төлөв байдал суурь нөхцөл байдалтайгаа уялдуулж, Эдийн засгийн хөгжлийн яам энэ орлогоо төлөвлөдөг байгаа Анар ТНБД-аа. Энэ дээр мэдэж будилаад байгаа зүйл байна уу, мэдэхгүй будилаад байгаа зүйл байна уу? Сангийн яам орлогын төлөвлөлтөд нь саналаа л өгдөг байх. Ирсэн тоог нь орлогыг нь бүрдүүлэх гэж энэ Сангийн яамны орлого бүрдүүлдэг харьяа институцүүд, гааль, татварын байгууллагууд энэ хэдэн байцаагчид маань хөөрхий өдөр, шөнөгүй, хоол нойргүй явдаг. Ийм зүйл байдаг.

Тэрнээс биш Сангийн яам энэ зардлаа багтаах гээд, санхүүжилт олох гээд орлогоо хиймлээр өсгөөд явдаг ийм зүйл огтоос байхгүй. Эдийн засгийн хөгжлийн яамаар орж гарахаараа Сангийн яамныхаа ажлыг мэдэхээ байчихдаг юм шиг байгаа юм. Тэр Анар дарга одоо хаа нэг газар суугаад сонсож байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам макро төлөвлөлтөө хийнэ. Намар ЗГ түүн дотроо Сангийн яам микро төлөвлөлт буюу салбар хоорондынхоо төлөвлөлт, эдийн засагт оролцогч төсвийн ерөнхийлөн захирагч нарынхаа төсвийг арайхийж багтаах гэж боож орж ирэх байх. Энэ ялгаануудыгаа их сайн ойлгоорой гэж захъя.

Тэгээд 1 асуулт байна Энхбаяр сайдаа. Уг нь боломж байгаа дээр биднийг ашиглаад аваасай гэж бодож байна. Юу вэ гэхээр 2 жилийн өмнө ЗГ-аас УИХ-д мэдүүлчихсэн 200 гаран хуулийн жагсаалт байгаа. 208 хуулийн 1080 заалт бүхий аль хэдийн төсвийн зардлыг хуваарилчихсан, салбар салбарын ийм хуулиуд байгаа. Энийгээ бид эргэж харахгүй, эргэж оролдохгүйгээр нөгөө төсвийн тэлэлтийг хязгаарлана, төсвийн хязгаарыг ДНБ-ий 25 хувьд багтаана гэдэг чинь дахиад л яг үлгэр болж үлдэнэ шүү. Энийгээ Их Хурлын гишүүд бид өөрсдөө салбар салбарын төлөөллүүд энийгээ мэдрэх ёстой. Төсөв тэлээд байгаа чинь төсвийн төлөвлөлтөд биш, эндээс бид салбар салбарын нөгөө баахан зардлыг нь баталгаажуулчихсан, хуваарилчихсан хууль батлаад байснаас л болж байгаа. Энийгээ бид эргэж хармаар байгаа юм. Нөгөө олон 90 хэдэн ажлын хэсэг Их Хурал дээр байгуулагдсан байна лээ. Харамсалтай нь түүн дотор энэ салбар салбарын тавьчихсан байгаа энэ зардлыг хэмнэх, илүү, дутуу энэ юм эдгээр юмнуудыгаа зохицуулалт хийх, эргэж харах нь нэг ч байхгүй байгаа юм байна лээ.

Тийм учраас тэр хуулиудаа оруулж ирэх үү Энхбаяр сайдаа? Намар төсвөө цуг өргөн барихдаа та нар зоригтой энэ 50 хуулиа бариад ороод ирээч. Уг нь сая энэ төсвийн хүрээтэйгээ дагаад ороод ирүүлчихсэн байсан бол энэ хавар хэлэлцээд, намар төсөв өргөн барихад чинь ганц нэг хуулийг нь уг нь амжаад баталчихвал, зардлаа бууруулахад чинь нэмэртэй байсан байхгүй юу. Та нарын энэ зардал нэг их айхтар макро бодлого гэж бараг байхгүй дээ. Тэр олон хуулиуд дээр хуваарилчихсан байгаа зардлыг л яаж багтаах вэ гэдэг л нэг ийм тоо бодож орж ирж байгаа. Тэрнээс биш энэ бодлого гэх юм үнэндээ байхгүй. Тэгэхээр тэр хуулиудаа яах вэ гэдгийг нэг та нэг хэлээдхээч, ямар төлөвлөгөө байгаа юм бэ? Хэрвээ тэрийгээ хийж чадахгүй бол бид ямар ч төсвийн шинэчлэл, төсвийнхөө зардлыг бууруулна, хэмнэлт хийнэ гэдэг ямар ч ойлголт байхгүй, чадахгүй. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ таны ярьж байгаа тун зүйтэй санал. Нийт 208 хуулиар зардлыг хуульчилчихсан. Зөвхөн цалин гэхэд салбар салбарын 30-аад хуулиар цалингийн өсөлтийг ингээд байнга уячихсан. Тэгэхээр энийгээ нийт зардлын, дээрээс нь цалингийн, энэ тэтгэвэр тэтгэмжийн, тэтгэвэр тэтгэмж дотроо хүртэл олон асуудлууд байгаа. Нэг мөр цэгцлэх асуудлыг хийхгүйгээр яг саяын Жавхлан даргын хэлж байгаа туйлын үнэн. Энийг цэгцлэхийн төлөө л ЗГ ажиллана. Ингээд Ерөнхий сайд үүрэг өгсөн, 4 чөлөөлөлтийн бодлогын хүрээнд эдийн засгаа идэвхжүүлэх. Ер нь төр, ЗГ ялангуяа хамгийн түрүүнд бүх хэмнэлтийн бодлогыг өөрөөсөө эхэлж байгаа. Ажлын хэсгүүд гарчихсан, ЗГ-ын давхардсан чиг үүрэг, бүтцийн уян хатан уялдаатай, үр ашигтай байдал дээр нэг бүрчлэн салбар бүрээр дүн шинжилгээ хийж байна. Ингээд энэ намар төсөв өргөн барихад нэлээн ахиц дэвшил гарсан, нэлээн үр ашигтай, бизнесээ дэмжсэн, хувийн хэвшлээ дэмжсэн, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, эдийн засаг дахь төрийн оролцоог нэлээн бууруулсан, төрийн өмчийн компаниудын менежмент, хувьчлалын асуудлыг урагшлуулсан ийм бодлогын эрс өөрчлөлтүүд орж ирнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Нөгөө талаасаа энэ төсвийн хүрээ өөдрөг гээд гишүүд яриад байгаа бас тийм тал бий. Энэ чинь засаг зорилт тавьж байна. Улс орноо урагшлуулъя, хөгжүүлъя, инфляцаа бага байлгая, эдийн засгаа өсгөө, төсвийнхөө орлогыг нэмэгдүүлъя. Орлого нэмэгдсэн хэмжээнд зарлагаа нэмье, зарлагын хүрээнд энэ цалин, тэтгэврээ нэмчихье гэсэн зорилт буюу Засаг даалгавар аваад байгаа юм. Жоохон өөдрөг гээд шүүмжлээд байгаа нь үнэн. Гэхдээ энэ бол Их Хурал энийг нь баталж

өгөөд, ЗГ-ыг шахах хэрэгтэй. Энэ зорилтоо биелүүл. Энэ зорилт шүү дээ. Энийг хэрэгжүүлэхийн төлөө л Засаг ажиллах хэрэгтэй. Тэрнээс бага болгоод, инфляцаа өндөр тавиад оруулбал эсрэгээрээ энэ их муу ЗГ байхгүй юу. Засаг сайн болохын төлөө л тэмүүлж байгаа бодлогоо оруулж ирж байгаа юм. Нөгөө талаар энэ чинь гадаад, дэлхий дахинд Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, ЗГ-ын бодлого, хөрөнгө оруулалт орчин чинь ингээд бас энүүгээр дамжиж мэдээлэл түгж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө засаг өөрөөс хамаарах бүгдийг хийнэ, дайчилна, зүтгэнэ. Ийм учиртай юм гэж.

Б.Жавхлан: Тэгвэл тэр нэр бүхий 200 гаран хуулийн жагсаалтаас намар төсөвтэй цуг нэлээн хэдэн зардлууд хасагдахаар, салбар салбарын хуулиуд орж ирэх юм байна гэж ойлголоо шүү Энхбаяр сайдаа.

Зарчмын зөрүүтэй санал гишүүдээс ирээгүй тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн манайхаас давхар хэн, хэн байдаг билээ? Лодойсамбуу гишүүн Эдийн засагт байдаг тийм ээ, ямар ч байсан. Та эдийн засагт унших уу? Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн Эдийн засгийн байнгын хороонд уншихъя. Төсөв дээр давхар? Төсөв дээрхийг нь манайхаас чинь давхар байдаг билүү? Ариунзаяа гишүүн ороод унших уу та? Аюушийн Ариунзаяа гишүүн Төсвийн байнгын хороон дээр танилцуулъя. Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.36 цаг

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Дараагийн асуудалдаа орёе. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг хэвээрээ байгаа биз дээ? Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, сайд нар бүгдээрээ орж ирэх ёстой шүү. Нямтайширын Номтойбаяр Монгол Улсын Шадар сайд, Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Сайнбуянгийн Амарсайхан ХЗДХ-ийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, С.Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Ганхуяг БХЯ-ны ТНБД, Билгүүн Монгол Улсын ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Заяадэлгэр Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Чулуунбат УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрдэнэтулга ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Энхтөр Шүүхийн сахилгын хорооны дарга, Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга дарга, Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Даваа-Очир СЕХ-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нарийн бичгийн дарга, Аззаяа АТГ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга, Ариунбуян ОБЕГ-ын дарга, Гантогтох эдийн засаг, ЗГХЭГ-ын Засгийн газрын хүний нөөцийн дарга, Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого,

зохицуулалтын газрын дарга, Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Энхтөр ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Хишигтогтох ХЗДХЯ-ны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга, Гансүх БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Санжрагчаа ШЕЗ-ийн Захиргаа, удирдлагын газрын дарга, Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Доржзовдын Энхтуяа гишүүнээр тасаллаа, Зулпхар гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүний нэрийг нэмж оруулаарай. Ингээд 6 гишүүнээр тасаллаа. Энэ дээр, 6 юм байна шүү. Аюушийн Ариунзаяа гишүүнээр асуултаа эхэлье.

А.Ариунзаяа: Би байнга хэлдэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөг ярихад жилийн төлөвлөгөө дэмий юм биш үү, энийг өөрчлөх юм биш үү гээд 2 дахь жилдээ ярьж байна. Тэгээд ер нь нөгөө яг энэ жилийн төлөвлөгөө гэж юу юм, юу оруулах ёстой юм, улсын жилийн төлөвлөгөө шүү дээ. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө байхгүй юу. Тэгээд төсөвтөө юу оруулах ёстой юм гэдгийгээ энэ том агуулгаар нь харчихмаар байгаа юм даа. Бусад улс орон чинь, манайх ч гэсэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед 5 жилээрээ төлөвлөөд, тэгээд 5 жилийн төлөвлөгөөндөө нийцүүлээд тухайн жил бүрийнхээ төсвөөр тухайн жилийнхээ төсвийнхөө орон зай, боломж нь юу байгаа юм, тэгээд чухлаасаа эрэмбэлээд тэгээд энэ жилдээ, энэ 5 жилийн төлөвлөгөөнөөсөө энэ жилдээ энэ хэсгээ хийнэ гээд төсвөө батлаад явдаг. Манайх төсвөө ч нэгд явдаг, жилийн төлөвлөгөөгөө ч нэгд явдаг. 24 оны төлөвлөгөөнд орсон заалтууд бүтэн жилийнхээ хугацаанд угаасаа гүйцэтгэл нь бага, 25 оных жишээлбэл гүйцэтгэл нь аудит сая энд тараасан байсан 20,9 хувьтай гэж байгаа байхгүй юу 25 оны төлөвлөгөөний хэрэгжилт. Тэгээд 26 оных бас л 20, 30 хувьтай л гарах байх.

Тэгээд бид чинь энэ жилийн, жил жилээрээ төлөвлөж байна гэххээд, тэгээд дараа жил нь энэ өнгөрсөн жилийнхээ төлөвлөгөөг мартчихаж байгаа байхгүй юу, хаячхаж байгаа юм. Тэр төлөвлөгөө нь биелсэн ч юм уу, үгүй ч юм уу, түүн дээрээ үргэлжлэх ёстой ч юм уу, үгүй ч юм уу. Тэгээд энэ төлөвлөгөөний асуудлыг болохлоор Эдийн засаг, хөгжлийн яам хуучнаар Төлөвлөгөөний комиссын үүргийг гүйцэтгэх Хятадын Хөгжил, шинэтгэлийн хорооны чиг үүргийг гүйцэтгэх ийм л зорилготой шүү дээ уг нь. Тэгэхээр өөрөө улсынхаа хөгжлийг юу гэж харж байгаа юм гэж явмаар байгаа байхгүй юу. Гэтэл одоо яаж байна вэ гэхлээр бүх газруудаас

саналуудыг нь хүлээж аваад, нэгтгээд, тэгээд оруулчхаж байгаа юм. Тэгээд нөгөө зарим салбарууд чинь заавал тухайн жилдээ юу гэдэг юм төлөвлөгөө жилийн бичих юм байхгүй байж болно шүү дээ, тэгээд зайлшгүй бич гэсэн учраас элдэв янзын эрээвэр хураавар юмнуудаа оруулчихсан. Гадаад харилцаа жишээлбэл гадаад айлчлалынхаа тоо хэмжээг нь хэвээр нь хадгална гэчихсэн байгаа.

Тэгээд л бүх газрууд өгч байгаа учраас ийм жижиг сажиг элдэв янзын асуудлууд орчхоод байгаа байхгүй юу. Жишээлбэл түрүүн би нөгөө чуулган дээр ч гэсэн хэлж байсан, дайвар ачаа тээшийг илүү сайн шалгадаг болно. Мөн түүнчлэн юу гэдэг юм төрийн албан хаагчдад статистикийн сургалт орно гэх зэрэг. Тэгэхээр үндсэндээ миний асуулт юу вэ гэхлээр жилийн төлөвлөгөө гэж уг нь яг юу байх ёстой юм бэ, Эдийн засаг, хөгжлийн яам юу гэж харж байгаа юм бол? Төсвөөсөө юугаараа ялгаатай юм бэ?

Б.Жавхлан: Хариулъя хэдэн номер вэ? 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Өнгөрсөн, парламентын өнгөрсөн 30 гаруй жилийнхээ үйл явцад дүгнэлт хийгээд, улс төрийн намууд зөвшилцөлд хүрээд, Үндсэн хуулиа өөрчлөөд, улс орон ер нь хөгжлийн нэгдмэл ийм цогц бодлоготой байна гээд Үндсэн хуульдаа заагаад, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа батлаад, тэн дотроо улс орон урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой байна. Тэр бодлогоо хэрэгжүүлэхийн тулд энэ чинь төсөв хүрээ, төсөв, жилийн төлөвлөгөө чинь ингээд хэрэгжээд явж байна шүү дээ. Тэгээд ингээд энд тэндээс нь эрээвэр хураавар юм цуглуулаад ингээд нэг нийлүүлээд л өгдөг гээд Ариунзаяа гишүүн өнөөдөр ямар хариуцлагагүй, хариуцлагагүй үгнүүд яриад байна. Монгол Улс хуультай улс. Хуулийн дагуу ЗГ Улсын Их Хурлын баталсан хуулийн дагуу, Үндсэн хуулийн зарчмын дагуу улс орныхоо хөгжлийн бодлогыг төлөвлөлтийг, төсвийн хүрээг хуулийн хугацаанд нь нийцүүлээд, төсвийн тусгай шаардлагад нийцүүлээд өргөн бариад явж байна шүү дээ.

Асуух юм байвал тэр салбар салбарт нь холбоотой асуулт асуу л даа. Энэ салбар дээр ийм асуудал байна, ямар учир шалтгаантай юм бэ, яагаад оруулсан юм гэж. Энэ чинь бүхэл бүтэн ЗГ байгууллагууд ажиллаж байна шүү дээ. Шаардлагаа тодорхойлоод, хэмжих нэгжтэй. Энэ өөр болсон, төлөвлөлт бол өөр болж байгаа юм. Хуультай болж байгаа, сахилгатай болж байгаа. Улс төрийн намууд хүртэл энэ 5 жилийн төлөвлөгөөг дагаж сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрийг боловсруулдаг болсон шүү дээ. Дур зоргоороо боловсруулахаа больсон. Хэрвээ энэ хөгжлийн хөтөлбөрт нийцэхгүй бодлого орж ирсэн бол сонгуульд нэр дэвшихийг нь, улс төрийн намыг нь сонгуулийн бүртгэлээс хасах хүртэл зохицуулалттай шүү дээ. Энэ бол улс төрөөс ангид төрийн бодлого, хөгжлийн бодлого тогтвортой байна, улс төржихгүй гэдэг үндэсний томоохон зөвшилцлийн үр дүнд хийж байгаа энэ бодлогын арга хэмжээ шүү дээ.

Бидний боловсруулсан 20 50 буюу 50 он хүртэл Монгол Улсынхаа хөгжлийн ерөнхий загвараа гаргаад ирлээ. 5, 5 жилээр явж байна. Одоо 2 дахь 5 жилийнхээ ажлыг хэрэгжүүлж байна. Гарч байгаа алдаа, оноогоо боловсронгуй болгоод яваад байна. Ингэж явж байгаа зүйлийг үгүйсгэх хэрэггүй, шаардлагагүй гэж ярих бол Их Хурлын гишүүнд тийм зохистой зүйл биш шүү.

Б.Жавхлан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Энхбаяр сайд та бид 2 угаасаа өөр, өөр юу гэдэг юм түвшнээр яриад, угаасаа огт ойлголцохгүй. Би урт хугацааны буюу 2050, 2030, 5 жилийг огт үгүйсгээгүй шүү дээ. Би нэг жилийн төлөвлөгөөг яриад байгаа байхгүй юу. Жил бүрийн чинь төлөвлөгөө гүйцэтгэл 20-хон хувьтай байгаад байна. Дараагийн жилийн төлөвлөгөөндөө орохгүй байна, хавар нь батлагдаж байгаа төлөвлөгөө чинь намар нь төсвөөрөө баталгаажихгүй байна. Төсөв энэ 2 чинь хоорондоо зөрөөтэй гэдгийг нь хэлээд байгаа юм. Тэгээд энэ хар даа энэ орж ирж байгаа зүйл, заалтууд чинь байна шүү дээ улсын хөгжлийн төлөвлөгөө юм бол төсвөөсөө юугаараа ялгаатай юм бэ гэдгийг би асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд ердийн яамдын хийдэг ажлыг бас энд оруулчихсан байгаад байгаа байхгүй юу. Маш энгийн л юм би уг нь хэлээд, ядаж энэ жилийн төлөвлөгөөгөө больдог байя, тэгээд тэр 5 жилийн төлөвлөгөөндөө нийцүүлж төсвөө баталдаг байя гэдэг асуудлыг л яриад байгаа байхгүй юу. Би зүгээр энгийн асуулт асууя. Яагаад жишээлбэл Дарханы эмнэлгийн.../минут дуусав/

Б.Жавхлан: Ариунзаяа гишүүний асуултыг гүйцээе, тодруулгын минутаа авлаа гэсэн үг.

А.Ариунзаяа: Үнэхээрийн тийм ялгаатай байгаа юм бол яагаад Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих асуудал хөгжлийн төлөвлөгөөнд орчхоод, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн асуудал орохгүй байгаа юм бэ тэгвэл? Энэ чинь ялгаатай биз дээ. Дарханыг хөгжүүлэх нь манай улсын хөгжлийн төлөвлөгөө юм уу, энэ төсвөөсөө юугаараа ялгаатай юм бэ? Улсын Их Хурлын гишүүд энэ хөгжлийн төлөвлөгөөг батлахдаа бүгдээрээ зарчмын зөрүүтэй санал гаргаад, өөр өөрсдийнхөө тойргийн төсвийн асуудлыг оруулдаг байхгүй юу даа. Би тэгээд энэ ажил сайн яваасай, цагаа үр бүтээлтэй ашиглаасай гэж яриад байгаа байхгүй юу. Тэгээд би танаас хариулт авахгүй, та угаасаа надад нийцэх хариулт өгөхгүй, би хариулт авмааргүй байна.

Б.Жавхлан: Гишүүн асуулт асуугаагүй учраас хариулт байхгүй. Тэгэхдээ яах вэ энэ Ариунзаяа гишүүний яриад байгааг би ойлгоод байна. Манай Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яамныхан нэг ийм юм бодох хэрэгтэй шүү. Энэ төлөвлөгөө гаргадаг ядаж форматаа өөрчилмөөр байгаа юм. Тэгэхгүй яг саяын асуугаад байгаа шиг, асуугаад байгаа энэ юу гарч ирээд байгаа байхгүй юу нэг ойлголтын зөрөө. Төсөв, төлөвлөгөө 2 чинь бараг ялгаагүй болчихоод байгаа юм. Энэ төлөвлөгөө хийж байна гээд баахан гишүүдийг үндсэндээ бараг хошхируулаад байгаа байхгүй юу. Тэгээд тойрог тойргийн төсөв тавьж байгаа юм шиг, бараг ялгаагүй болчихоод байгаа юм.

Тэгэхийн оронд яг хүрээ шигээ энэ төлөвлөгөөгөө нэг хэдхэн яг ийм макро тоонууд тавьдаг, хүрэх салбар салбарынхаа зорилтуудаа тавиад л, төлөвлөгөөгөө баталчих хэрэгтэй. Тэгэхгүй ингээд яг аягүй детальчлаад ингээд микро түвшинд задалчихаар төсвөөсөө бараг ялгаагүй юм болоод, энд л орохгүй бол намар төсөв юм орж ирэхгүй юм шиг гишүүд ингэж ойлгоод, ингээд явж байдаг. Гэтэл намар орж ирж байгаа төсөв чинь энэ төлөвлөгөөтэйгөө, энэ төлөвлөгөөнийхөө яах вэ хүрэн дотор байдаг л даа. Энэнээсээ халих боломж байхгүй. Тийм учраас энийгээ төлөвлөгөөнийхөө энэ баталж байгаа форматаа илүү их компактно болгоод, яг хүрэх зорилтуудаа нэг хэдхэн макро тоонуудаа тавиад л оруулж ирдэг болчихвол илүү их ойлгомжтой л болох юм даа. Энхбаяр сайд санаж байгаа байх энэ хууль анх орж ирж байхдаа бас нэг тийм арай өөр үзэл баримтлалтай, улс төрийн нэг ийм өнцөгтэй орж ирж байсан шүү дээ. Тэр ач холбогдол одоо бол би байхгүй гэж харж

байгаа юм. Тийм учраас энэ форматаа өөрчлөх талаар эргэж хараарай. Баярмагнайн Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Байнгын хорооны даргатай санал нэг байна. Энэ төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь ер нь бага гараад байгаа чинь яг хэтэрхий деталь төлөвлөгөө, дээр нь энэ хөрөнгө оруулалт шаардлагатай ажлууд төлөвлөгөөндөө тусгачихдаг. Тэгээд тэр нь буцаад ингээд хэрэгжихгүй болохоор ингээд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь ингэж бага орж ирээд байгаа юм. Би нэг зүгээр энэ өнгөрсөн 25 онд 26 оны жилийн төлөвлөгөөг Эдийн засаг, хөгжлийн яам тухайн үед танилцуулж орж ирэхдээ нөгөө төрийн албан хаагчийн 9 хувийн цомхотгол гэж нэг тоо орж ирээд, тэгээд эндээс би нэг тодорхой тайлан бүрдүүлээд явж байгаа. Тэгээд яах вэ төсөв хэмнэгдэх, энэ урсгал зардлыг бууруулах ёстой гэж үзэж байгаа. Тэгэхдээ яг энэ төлөвлөгөөний үр дүнгээр нь ингээд үзэхээр жишээлбэл ХЗДХЯ-наас асуухад 700 энгийн цагдаа, Байгаль орчны яамнаас асуухад 262 байгаль хамгаалагч ажлаас чөлөөлөгдсөн байгаа юм. Тэгэхээр одоо би энэ дээр яах гээд байна нөгөө дахин инженерчлэл гээд нэг ийм зүйл хийгдээд байсан. Тэр ер нь яг юу болж байгаа бол? Яг тэр бүтэц, бүрэлдэхүүнээ их зөв тооцож байж, урсгал зардлаа зөв зохистой бууруулахгүй бол энгийн нэг зүгээр ингээд хэв журмын цагдаа, байгаль хамгаалагчаа ингээд ажилгүй болгосноор улсын хөгжил явагдана, явна гэж харж байгаа юм уу гэдэг асуудал.

Дараагийн нэг зүйл нь би өнгөрсөн оны төсөв батлах ч элгийн юм л болсон л доо. Тэрийг хүн болгон л мэдэж байгаа. Тэр үед яах вэ энэ 12 оноос хойш ашиглаж байгаа энэ сонгуулийн санал тоолох машиныг нэг бүрэн шинэчилчихье гээд нэг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээс 0,03 хувийг танаад, тэгээд тэрийгээ ТББХ-гоор дэмжүүлээд уул нь Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Тэгээд тэр маань нэгдсэн чуулган дээр дэмжигдээгүй хасагдсан. Тэгэхдээ тэр мөнгө буцаад төсвийн ерөнхийлөн захирагчдаа бол очоогүй гэж би хараад байгаа юм. Нөгөө өөр бүтээн байгуулалт руу шилжээд л явчих шиг болсон. Тэгтэл ингээд СЕХ энэ дээр хариулаад, яг нөгөө санал тоолох машины ачаалал маань ер нь хэр байгаа, энэ ирэх энэ жилийн энэ нөхөн сонгууль, ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгууль гээд энэ чинь төр байгуулагдах явц шүү дээ энэ чинь сонгуулийн санал тоолох төхөөрөмж гэдэг чинь. Мэдээж иргэд, олон нийтийн зүгээс янз бүрийн хардлага төрдөг. Тэгэхдээ аль болох энийг нь арилгах зорилгоор бид ажиллах ёстой байгаад байгаа. Тэгээд энэ дээр ирэх жилийн төлөвлөгөөнд үнэхээр деталь сууж байгаа бол СЕХ энэ дээр юу гэж харж байгаа вэ? Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр юу гэж харж байгаа вэ?

Тэгээд дахин инженерчлэлийн асуудлыг нэг бүхэлд нь нэг хийж үзээд Энхбаяр сайдаа, тэгээд тэрнийхээ дагуу энэ урсгал зардал бууруулах тийм саналыг оруулж ирвэл уул нь зүгээр байгаад байгаа юм. Тэгэхгүй ийм автоматаар ингээд квот өгөөд, тоо тавиад, урсгал зардал буураад яваад байхаар энэ нь өөрөө буцаад ард иргэддээ хохиролтой зүйл болчих вий л гэсэн ийм санаа зовнилтой байгаа юм.

Б.Жавхлан: Асуултад хариулъя, 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Баярбаатар гишүүний хөндсөн асуудал яг бодит байдал үнэн. ЗГ-аас ажлын хэсгүүд гаргаад бүхий л төрийн яам, агентлагуудын чиг үүргийн шинжилгээ хийж байна. Төсөв өргөн барихад нэлээн цэгцэрчихсэн орох байх. Ноднин яг өдийд энэ төсөвтэй холбоотойгоор энэ 9 хувийн төрийн албаны цомхотголыг хуульчлан баталсан. Гэхдээ тэнд нэг байсан заалт нь хэрэгжүүлэхдээ

чиг үүргийн шинжилгээ хийж хасах гэдэг цомхотгох гэдэг асуудал байсныг тэр чигт нь 9 хувиараа тайрчихсан нэг асуудал бий. Тэрэнтэй холбоотой зарим салбарт алдаа гарсан, гомдол гарсан юмнууд байгаа. Энийг ингээд засах үүргийг Ерөнхий сайд өгөөд, энэ дээр тохиргоонуудыг хийгдээд явж байгаа.

Энэ хөгжлийн бодлогын хэрэгжилтийг их бага гарсан гэж яриад байх юм. Үндэсний аудитын газар энийг хянаж байгаа, 23 онд 70,1, 24 онд 57,2, 25 онд 58,1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Яагаад ингэж гарч байгаа учир шалтгаан зөвхөн өнгөрсөн онд гэхэд 155 төсөл 2,4 их наядыг Их Хурал дээр оруулаад ирсэн. Нөгөө хөгжлийн бодлогод тусаагүй, хөтөлбөр тусаагүй зүйл орж ирсэн байхгүй юу. Энэ чинь өөрөө нэг хөгжлийн бодлогоо бүхэлд нь булингартуулаад, хэрэгжилт дээрээ энэ чинь техник, эдийн үндэслэл байхгүй, үр дүн, үр ашгаараа олон зүйлээрээ дараа нь хасагдаад, ингээд төсвийн тодотгол хийхэд төсвийн хүрээгээ хөгжлийн бодлогоо тодотгохгүйгээр зөвхөн санхүү талд нь тодотгоод явахаар, эх үүсвэргүй болчихсон олон төсөл, хөтөлбөрүүд чинь ингээд хэрэгжихгүй бага гараад байгаа юм.

Тэр асуудал хаанаа байгаа гэдгээ их сайн ойлгох хэрэгтэй байна бүгдээрээ. Энэ чинь их шүү дээ. 155 төсөл 2,4 их наядыг л хөндлөнгөөс оруулж байна гэсэн үг. Нөгөө батлагдсан хуульчилсан бодлогын дэргэд хажуугаар. Тэгээд энэ чинь яг хуулийнхаа тусгай шаардлагаа хангаад ирэхээр чинь ихэнх нь хэрэгжихгүй хасагдаад, тэгээд л төсвийн тодотголын байдал үүсдэг. Тодотгонгуут нь Их Хурлын нэг орхигдуулж ирсэн юм бол яг жилийн төлөвлөгөөгөө давхар бас тодотгож явах ёстой, тэрийгээ хийж явдаггүй юм байна лээ. Тэгээд ингээд тооны зөрөө гараад байдаг, бид энийг хөөцөлдсөн л дөө. Яагаад ийм байдал үүсчхэв гээд яг ингээд үзэхээр чинь яг хөндлөнгөөс орсон саналын хэмжээнд л нөгөө хөтөлбөрийг чинь, хөтөлбөрийг болохоор 5 жилийн батлагдсан гол эхээсээ бариад л аудит дүгнээд явчхаж байгаа шүү дээ. Тэгэхээр ийм нэг жоохон харах өнцөг гэдэг юм уу, үйл ажиллагааны зөрөө гарч ирээд байна л даа. Тэрнээс ингээд нэг зах замбараагүй болоод, хяналтаа алдаад байгаа юм байхгүй шүү дээ. Сангийн яам тэр төсөв тооцоотой холбоотой юм байсан уу сая.

Б.Жавхлан: Ажлын хэсэг 1 номерын микрофон, СЕХ-ноос, өөрийгөө танилцуулаарай.

Д.Даваа-Очир: Сонгуулийн ерөнхий хороо Даваа-Очир. Би Баярбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улс 2011 онд Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль батлагдсан. Энэ үеэс эхлээд бид 12 оноос эхлээд өнөөдрийн байдлаар 38 ээлжит болон нөхөн, дахин сонгуульд бидний ярьдгаар санал тоолох төхөөрөмжийг ашиглаад явж байгаа. Анх 12 онд 3 мянган санал тоолох төхөөрөмж орж ирсэн, энэ нь марк нь ICP 1 гэж. Үүнээс бид 730-ийг нь акталчихсан байгаа, үлдэгдэл нь өнөөдөр ажиллагаанд бэлэн байгаа. Энэний марк нь хуучирсан, ихэнх нь ICP гэдэг марктай ийм санал тоолох төхөөрөмж байгаа. 2013 онд бид 507 ширхэг ICP 2 гэдэг тоног төхөөрөмж оруулж ирээд, одоо энийг ашиглаад байж байгаа. Энэ онд мянган ширхэг санал.../минут дуусав/

Б.Жавхлан: Хариулт дутуу гэж байна, нэмэлт минут өгье.

Д.Даваа-Очир: Санал тоолох төхөөрөмжийг.../үг тасрав/

Б.Жавхлан: Микрофон чинь дутуу орчихлоо шүү, одоо эхнээс нь хариулна.

Д.Даваа-Очир: Худалдаж авахаар төсөвт хөрөнгө мөнгө тусгасан байна л даа. Тэгэхээр энэ ирэх онд авахад бид 2027 оны сонгууль явахад ихээхэн эрсдэл үүснэ. Тийм учраас төсвийн тодотгол явбал энэ ондоо багтаж энэ хөрөнгө мөнгөний асуудал шийдэхгүй бол Ерөнхийлөгчийн сонгууль ихээхэн эрсдэл үүсэх магадлалтай гэдгийг энд хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Б.Жавхлан: Баярбаатар гишүүн тодруулъя.

Б.Баярбаатар: Би нөгөө хяналт алдагдсан гэж ерөөсөө хэлээгүй Энхбаяр сайдаа. Төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төлөвлөгөөг би анхнаасаа бүлэг дээр хэлэлцэж байх үед дэмжиж байгаа байр сууриа илэрхийлээд явчихсан юм. Тэгэхээр энэ байр суурь дээрээ өнөөдөр байгаа. Түрүүн Байнгын хорооны дарга хэлсэн учраас ер нь яаж энэ хэрэгжилтийг нэмэгдүүлэх боломж байна вэ?

Дараагийн нэг асуудал нь юу вэ гэхээр түрүүн та яг голыг нь олох хэрэгтэй гээд, манай Байнгын хорооны дарга энэ дээр анхаарах болов уу гэж би бодож байна. Энэ төсөв хэлэлцэх Их Хурлын энэ чуулганы дэгийн асуудал дээр бид нөгөө эргэж харах болчихсон юм байна. Мэргэжлийн Байнгын хороо нь дэмжээгүй санал Их Хурал дээр ороод дэмжигдээд гараад ирдэг. Нөгөө Төсвийн тухай хуулиа зөрчсөн төсөл, арга хэмжээнүүд нэмэгдээд ороод ирдэг. Тэгээд аль болох энэ хууль зөрчиж байгаа энэ төсөл, арга хэмжээг нэгдсэн чуулган дээр ер нь заавал санал хураалгах хэрэг байдаг юм уу, үгүй юм уу. Энхбаяр сайдын хэлээд байгаа зовлон тэр байхгүй юу. Мэргэжлийн Байнгын хороо нь, Байнгын хороод нь бүүр дэмжихгүй ингээд яачихсан санал тэр нэгдсэн чуулган дээр ороод л гишүүд бараг тухайн үед танхим хоосон юм уу, эсхүл ямар нэгэн байдлаар кнопдоо хүрэхгүй байхад л тэр нь босоод ирчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр эдгээр зүйлүүдийг арилгачихвал энэ нөгөө гол зовлон нь эндээ байгаа юм болов уу гэж би хараад байгаа. Тэгэхээр энэ дээр Байнгын хороон дарга та нэг анхаарал хандуулаад, энэ Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хуулийн төсөл дээр нэмэлт, өөрчлөлт явагдаж байгаа үед гол анхаарах асуудал энэ болов уу. Энэ чинь цаанаа төсөл, арга хэмжээ, улсын төсвийн хөрөнгө гээд олон зүйлүүд шийдэгдэж байгаа учраас анхаарах ёстой асуудал болов уу гэж. Тэрнээс би ямар нэгэн хяналт алдаад ингэж байгаа юм биш, гол нь бид яаж энэ хэрэгжилтийг нь нэмэгдүүлэх вэ л гэдэг гол бодлого гаргая л гэсэн тийм санааг агуулж хэлж байгаа. Санал, баярлалаа.

Б.Жавхлан: Баярбаатар гишүүн санал хэллээ. Энхбаяр сайдаа түрүүний асуултад та нэг ямар бодолтой байгаа юм бэ, хариулт мэдээлэл өгөөч? Ариунзаяа гишүүн ч асуулаа, би ч бас тодрууллаа. Төлөвлөгөө хийх энэ формат дээрээ та нар энийгээ өөрчлөх бодол байгаа юу? Энийгээ арай хялбаршуулаад компактны болгоод, ойлгомжтой болгоод, төлөвлөгөө гэхээр наадах чинь макро төлөвлөлт шүү дээ, микро биш. Тэгэхээр яг салбар салбарын яг ингээд нэг зорилтот түвшин, эрүүл мэндийн салбарын зорилтот түвшин, боловсролын яамны зорилтот түвшин гэх мэтчилэн.

Ж.Энхбаяр: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль гээд бид хуулийн үнэлгээ хийгдэж байна. Манай Лувсанжамц гишүүнээр ахалсан ажлын хэсэг гарчихсан, ажиллаж байна. Цаглавраасаа авхуулаад нэлээн ер нь юмнууд боловсронгуй болгох талдаа. Цаашдаа бүгдээрээ боловсронгуй болгох тал руугаа улам тэмүүлэх л ёстой. Өнөөгийн бидний яг хэлэлцэж байгаа байдал энэ чинь аягүй ахисан түвшинд хүрчхээд байгаа нь энэ шүү дээ. Их л задгай, их л дур зоргын, их л баримжаагүй

явдаг байсан бол одоо яг 5 жилдээ баригдаад л, хөтөлбөртөө баригдаад л, жилийн төлөвлөгөө нь төсвийн хүрээндээ баригдаад л, тэнд нь төсөв нь баригдаж цохогдоод л. Ер нь нэлээн шаардлагууд их өөр болсон. Хуулийн шаардлагууд ч өндөр болж байгаа. Тэгээд боловсронгуй болгох талд нь ажиллана, тэгээд ажилгүй яах вэ, таны саналыг бүрэн хүлээж авна.

Б.Жавхлан: Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Сая Баярбаатар гишүүнийхтэй ер нь давхцаж л байна. Тэр нөгөө цомхотголоо гээд ажил үүргийн давхцал юмыг нь харгалзаж үзэхгүйгээр явчихсан. Тэгсэн мөртөө зарим газар нөгөө албан ёсны цомхотгол нь байхгүй тухайлбал энэ сумдын соёлын төвүүдэд жигдхэн байна лээ л дээ. Жишээ нь хангайн бүст гэхэд нийтдээ 58 сум байгаа, тэгээд л яг жигдхэн 6 орон тоотой бол нэгнийх нь зүгээр цалинг нь өгөхөө больчихсон. Орон тоо нь байгаад байдаг харахаар, цаасан дээр 7 орон тоотойгоо, цалинг нь баталж өгөхдөө 6-г явуулаад ингээд тэгээд бөөн асуудал үүсчихсэн. Хэнийгээ хасах вэ, аз болж нэг хүн амьтан тэтгэвэр тэтгэмж, тэтгэвэрт гарч байгаа бол тэрийг нь нэг нэмж авахгүй аргалаад, тэгээд бүжгийн багшаа явуулах уу, хөгжмийн багшаа явуулах уу, техникчээ явуулах уу, үйлчлэгчээ явуулах уу гээд л хөөрхий ингээд л зовлонтой байна лээ л дээ.

Тэгэхээр хэлэх гээд байгаа гол санаа бол энэ ажиллах чиг үүргийнх нь давхцалыг хараад, тэгээд цомхотговол цомхотгосон шиг цомхотгоод, цаасан дээр тэр орон тоо нь байгаа юм байна лээ л дээ цаасан дээр. Тэгэнгүүтээ цалин нь байхгүй болчихсон, тэгээд энийг чинь яг цомхотгол гэж нэрлэх юм уу гэдэг нэг ийм асуулт байгаад байна. Үнэхээр, тэгэхээр асуулт ер нь цаашдаа манай Энхбаяр сайдын жишээ нь хамтарсан засгийн үед ХХАА-н сайдаар ажиллаж байхад ч явуулсан бодлогын үр дүн жишээ нь энэ жил ноолуур их аятайхан байна шүү дээ үнэ, дахиад цаашаагаа нэмэгдэх болов уу гэж найдаж байна. Тэгээд Монгол Улс яг энэ салбарт зөв бодлого явуулсны л үр дүн байх. Тэгэхээр цаашдаа энэ хэмнэлт яг ард иргэдийн хүсэж байгаа, хүсэмжилж байгаа хэмнэлтийг ер нь яаж гаргах юм бэ? Энэ төлөвлөгөөнд ер нь санаснаар туссан зүйл байна уу? Ер нь цаашдаа бид эдийн засгаа хөгжүүлбэ, энэ улс орныхоо эдийн засгийн байдлыг сайжруулъя гэвэл яг хэмнэлт дээр ямар бодлого баримтлах вэ? Энэ дээр бодож төлөвлөж байгаа зүйл байна уу гэж би Энхбаяр сайдаас асууя?

Б.Жавхлан: 5 номерын микрофон ажлын хэсгийн, Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бид нөгөө 126 гишүүнтэй парламент байгуулаад олон намын хамтарсан ЗГ гээд энэ ЗГ-ын бүтцийг данхайлгасан зүйл байгаа. Тэгэхээр бүх чиг үүрэг дээр энэ дүн шинжилгээ хийгдэж байна. Чиг үүргийн шинжилгээ хийгдэж байна. Давхардсан, уялдаагүй олон асуудал гарч байгаа. Өнөөдөр хүртэл засаг дээр бид төрийн өмчийн компаниудын бүтэц, зохион байгуулалт, уялдааны асуудлыг ярьж байна. Бүх төрийн агентлагуудыг ингээд ярилаа. Тэгээд арга хэмжээнүүд аваад эхэлж байгаа. Намрын төсөв дээр энэ асуудал цоо шинээр орж ирнэ.

Ялангуяа эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, төрийн өмчийн компаниудын бүтэц, зохион байгуулалт, менежментийг сайжруулах, хөрөнгийн удирдлагыг сайжруулах, тэр хувьчлалын бодлого гээд орж ирнэ. Төрийн албанд нэлээн чиг үүргийн давхардлуудыг арилгасан, цэгцэлсэн ийм өнөөдрийн хурлаар гэхэд бүх яамнуудад сая үүрэг өгөгдөөд л гарлаа. Бүх бүтцийн юмнууд, давхардсан

чиг үүргүүдээ, чиг үүргийн доторх хувь хэмжээг бүгдийг нь яг нэгдсэн бодлогоор цэгцэл гэдэг үүрэг өгөгдөөд явж байна. Тэр 9 хувийн нөгөө тайралт бол бодлогын алдаа болсон гэдгийг Ерөнхий сайд хүлээн зөвшөөрсөн. Орон нутгийнхтай нэг боловсронгуй болгох, цэгцлэх ийм ажлуудыг өгөөд явж байгаа юм. Зарим салбарт нэмэгдэх хэрэгтэй салбар байна, зарим салбарт бүүр татан буулгаад, бүүр төрийн бус байгууллагад, иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх чиг үүргүүд ч байна. Зарим бүүр хэрэгжүүлэх төр хэрэгжүүлэх шаардлагагүй чиг үүргүүд ч юм уу, татан буулгачихмаар ч чиг үүргүүд байна. Энэ болгоныг бид ингээд цэгцлээд, энэ ЗГ яг энэ дээрээс л хэмнэлтүүд хийгдэж байгаа. Засаг байгуулагдсан өдрөөсөө л хэмнэлтийн горимд ажиллаж байгаа. Эдийн засгийн форумас авхуулаад амин чухал биш шаардлагагүй гэж үзэж байгаа хөрөнгө оруулалт, арга хэмжээнүүд бүгдийг нь цуцалж байгаа. Гадаад, дотоод томилолтоос авхуулаад арга хэмжээнүүд.

Б.Жавхлан: Доржзовдын Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Бусад гишүүдтэй санал нэг байна. Ер нь энэ төсөв төлөвлөгөөнд бид ингээд л 5 сард энэ төсвийн хүрээгээ хэлэлцээд л, төлөвлөгөөгөө хэлэлцээд л гаргачихдаг. Яг төсөв хэлэлцэхэд л тэгээд л нөгөө гишүүд өөр өөрсдийнхөө тойргийнхоо юмыг барьж орж ирээд л, тэгээд л ханцуйн дотроо энэ нэг өөрчлөөд оруулдаг энийгээ энэ жилээс эхэлж маш хатуу байх хэрэгтэй. Тэгээд ямар гишүүд юу хийгээд тийм юм оруулаад ирдэг юм тэрийг нь зарлах хэрэгтэй. Тэгээд энэ дээр маш хариуцлагатай хандах хэрэгтэй гэж бодож байна. Энэтэй санал нэг байна.

Энэ төлөвлөгөөтэй холбоотой нэг асуулт байна. Энэ төлөвлөгөө дээр ингэсэн байна л даа. Ер нь манай төсвийн ихэнх нь энэ халамжид яваад байна, хавтгайрсан халамж байна гэж маш олон жил ярьж байгаа боловч бид энэ дээр нэг реформ хийж чадахгүй байна л даа. Тэгээд алдар цолтой ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хамгийн зорилтот бүлэгт чиглэгдээгүй хөтөлбөр бөгөөд нийт зардлын 65 хувь нь хүн амын амьжиргааны түвшин хамгийн өндөртэй буюу буюу, хамгийн өндөртэй 20 хувьд хуваарилагдаж байна гээд тэгсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ахмад настнаа хэлээд байгаа юм уу, алдар цолтноо хэлээд байгаа юм уу? Яг ингээд энэ төлөвлөгөө дээрээ биччихээд, тэгээд энийгээ хуваарилагдаж байна гэххээд, энийгээ яагаад засаж залруулахгүй байгаа юм бэ?

Харин зорилтот бүлэгт чиглэсэн зардал 26,4 хувийг эзэлж байна. Тэгээд нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулж, оновчлох, ахмад настанд чиглэсэн цогц халамж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, асаргааны хувилбарт үйлчилгээ болон эрүүл, идэвхтэй наслалтыг дэмжихэд энэ халамжийг өгөх шаардлагатай байна гээд энэ дээр биччихсэн байна л даа. Тэгээд 26 оны энэ төсөв дээр энэ ахмад настны болон амьжиргааны төсөв дээр энэ 50 хүртэлх ахмад настныг халамжилж байгаа энэ халамжийн үйлчилгээний газруудад барилга байгууламж, барилгын ажлын гүйцэтгэл нь 50-аас дээш хувьд хүрсэн бол 500 сая төгрөгийн санхүүжилтийг нэг удаа олгоно гэж ингэж заачихсан байдаг. Гэтэл энэ журмаар 2026 онд нэг ч ААН ийм энэ нэг удаагийн тэтгэлэг аваагүй байгаа байхгүй юу. 25 онд ч гэсэн энэ гүйцэтгэл маш дутуу байдаг. Ер нь манайд нэг асрамжийн газар хувийн 10-аад асрамжийн газар байдаг. Одоо энэ хувийн асрамжийн газрууд чинь хаалгаа барихад яг ойрхон байна.

Ганцхан байгаа энэ Батсүмбэрийн асрамжийн газарт очер дараалал их байна. Тэгэхээр энэ Асралт хүүхдүүд, Тереза эх гээд энэ асрамжийн газрууд чинь

хаалгаа барих гээд байна гээд бидэнд ийм санал хүсэлт өгөөд байдаг. Тэгээд яг энэ цаасан дээр бичсэн энэ тусламжаа ингээд өгчихөд юу нь болохгүй байгаа юм бэ? Хэрвээ хэтэрхий хатуу журамтай байгаа юм бол тэр журамдаа өөрчлөлт оруулж болдоггүй юм уу? Хөдөө орон нутгаас хүртэл Дашинчилэн Булган аймгийн Дашинчилэн сумд асрамжийн газар ажиллуулж байгаа ахмад настан өчигдөр ирж надтай уулзлаа. Жоохон барилга байгууламж дээрээ нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай байна, энэ бичиг цаасыг нь өгөхөөр бидэнд ингээд энэ тэтгэмж чинь олгогдохгүй байна гээд гомдол мэдүүлээд байдаг. Тэгэхээр энэ дээр журам дээр нь өөрчлөлт оруулах ёстой юм уу, яах ёстой юм бэ? Энэ дээр Нийгмийн хамгаалал.../минут дуусав/

Б.Жавхлан: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хэн байна вэ? Энэ чинь уг нь дуудсан уу? Манай эрхлэх асуудал биш учраас ирээгүй юм байна. Асуултад хариулах зоригтой хүн байна уу? Зоригтойгоороо 5 номер Энхбаяр сайд хариулъя гэж байна.

Ж.Энхбаяр: Энэ ТББХ-ны эрхлэх асуудлын хүрээний асуулт биш тул энэ талын нөгөө албан хаагчид ирсэнгүй. Тэгээд танд би асуултыг уламжлаад, хариултыг нь аваад, өөрийн биеэр танд хүргэж өгье.

Б.Жавхлан: Энхтуяа гишүүнд баярлалаа. Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. 2022 онд Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсан. Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулах үндэс нь 2019 онд 20 оны Алсын хараа баталж байх үеэс гарсан зүйл л дээ. Тэгээд энэ их чухал. Энэ эдийн засаг болон хөгжлийн төлөвлөлтөө нэгдсэн байдлаар хийдэг энэ бусад улс орны жишиг, манай өнгөрсөн хугацааны жишиг л дээ. Социализмын үеийн төлөвлөгөөний комисс гэсэн үг. Тэгэхлээр энэ байдлаар ажиллаж байгаа, өнгөрсөн хугацаанд зохих түвшний үр дүнгүүд гарч байгаа учраас бид энийг сайшаах ёстой шүү. Тэгэхгүй бол Сангийн яаман дээр аваачаад, хөгжлийнхөө жишээ нь бодлогыг, төлөвлөлтийг нэгтгэдэг юм шиг ийм ойлголт дандаа Их Хурал дээр явж байсан, дандаа ийм процесс явж байсан юм. Тэгээд өнөөдөр Эдийн засаг, хөгжлийн яамныхан одоо ирчихсэн энд бүх асуудал хариулаад сууж байгаа нь өөрөө их чухал ажлын үр дүн шүү гэдгийг би зориуд хэлж байгаа юм.

Би яах вэ манай Байнгын хорооны шууд эрхлэх асуудлын хүрээ биш боловч Энхбаяр сайдын өөрийнх нь эрхлэх асуудлын хүрээ учраас би нэг зүйл асууя гэж байгаа юм. Мал эмнэлгийн дэвшилтэт технологийн үйлдвэр, Мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгаа, туршилтын төв байгуулах ийм жишээ нь асуудал зорилт бол улсын 5 жилийн төлөвлөгөөнд орчихсон юм. Энэ 5 жилийн төлөвлөгөөнд орчихсон. Гэхдээ 27 оныход тусгагдаагүй байна. Гэхдээ 5 жилийн төлөвлөгөөнд орохдоо 27 онд эхлүүлнэ гэхчхэн байсан юм. Энийг Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн дээр л гол нь энийг барьж байгаа шүү дээ. Тэгээд энэ их чухал зүйл. Та энийг өөрөө ХХАА-н чиглэлийн асуудал эрхэлсэн сайд байсны хувьд их сайн мэдэж байгаа. Бид чинь үндсэндээ вакцинаа өөрөө дотооддоо үйлдвэрлэх бүрэн боломжтой шүү дээ, манай хүрээлэнгүүд энийг чинь оюуных нь өмчийг нь бий болгочихсон, судлаад бий болгочихсон, оношлууруудаа хийх боломжтой. Гадаадаас авч байгаа бид энэ малын эм, эмнэлгийн хэрэгслийнхээ бараг 80 хувийг гадаадаас экспортоор авч байгаа, энийг орлох байдлаар бид энийг чухалчилсан.

Энэ салбарын хөгжил чухал. Цаашлаад манай хүн амын хүнсний аюулгүй байдалд чухал.

Нөгөөтээгүүр энэ импортыг орлох ийм төрлийн үйл ажиллагаа гэж байгаа юм. Тэгэхээр энийг яагаад та хэд маань төлөвлөгөөндөө тусгасангүй вэ гэдэг ийм асуулт байгаа юм? Энийг тусгаж байж бид өнгөрсөн жил манай ХАА-н салбар чинь ДНБ-ий өсөлтийн 30 хувийг хангачихсан. Цаашдаа ч гэсэн их чухал байх юм байна гэдэг бид зорилт тавьчихсан байж байгаа. Тэгээд энийг та бүхэн ямар бодолтойгоор цаашдаа авч явах юм бэ гэсэн энэ дээр тодорхой хариулт өгөөч гэж?

Б.Жавхлан: Хариулт ажлын хэсгийн 5 номер.

Ж.Энхбаяр: Зулпхар гишүүн их чухал асуулт хөндлөө. ХАА-н салбар, ХАА, хөнгөн хүнсний үйлдвэр бол манай хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар. Солонгоруулах гол салбар. Үүн дотроо МАА, 250 мянган малчин өрх, үүнээс 700 мянган иргэний амьдрал ахуй энэ салбартай холбогдож байгаа. Ингээд гол суурь болсон малыг эрүүлжүүлэх гол бодлого Био комбинат буюу энэ био бэлдмэл, оношлуур, вакцин, төрөл бүрийн ийм урвалжийг өөрсдөө дотооддоо үйлдвэрлэх, тэр чадавхаа бүрдүүлэх ёстой гэдэг энэ зорилт ХАА-н салбарын тэргүүлэх зорилтуудын нэг. Тэгэхээр энэ чиглэлээр гарч байгаа бүх л санаачилгуудыг дэмжинэ. Ялангуяа Био комбинатыг шинэчлэх, иж бүрэн шинэчлэх асуудлыг гадаадын зээл, тусламжаар хөөцөлдөж байгаа. Дотооддоо үндэсний чадавхыг хөгжүүлнэ.

ХАА-н чиглэлийн гол хүрээлэнгүүдийнхээ үйл ажиллагаа, судалгаан дээр бид бодлогын дэмжлэг үзүүлээд ажиллаж байгаа. Тэгэхээр ХАА-н салбар 25 онд 33,2 хувийн өсөлт үзүүлж, Монголын эдийн засаг 6,8 хувь өссөн. Үүний 2,9 нэгжийг нь ХАА бүрдүүлсэн. Тэгэхээр бид уул уурхайгаасаа ингээд хөгжүүлэх гол чиглэл маань энэ ХАА байгаа юм. Тэгэхээр энэ ХАА-н чиглэлийн бодлогуудыг бүх талаар дэмжиж, урамшуулж явна.

Б.Жавхлан: Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Энхбаяр сайдаа баярлалаа. Тэгэхлээр яах вэ тодорхой тэгвэл та бүхэн энэ төлөвлөгөөнд оруулаадхаач гэж байгаа юм. Төсөв дээр ч гэсэн тавиад ороод ирээч гэж байгаа юм. Бид энэ Шинжлэх ухааны хүрээлэнгүүдээр явчихсан. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдээр яваад, эхний хууль дээр нэмэлт, өөрчлөлтөө оруулаад, эхний байдлаар батлуулчихсан. Уянга гишүүн энэ хажууд сууж байна. Бид шинжлэх ухаанаа ямар нэгэн байдлаар тэтгэхгүйгээр энэ улс орны хөгжлийн тухай яриад ерөөсөө хэрэггүй. Тэгээд л бид зөвхөн тэтгэвэр ярьдаг, эсхүл цалин ярьдаг нэг ийм хөгжлийн бодлоготой улс шиг боллоо шүү дээ. Тэгэхээр зэрэг та бол өөрөө хөгжлөө барьж байгаа хүний хувьд тодорхой салбарт гарцаа байхгүй суурь асуудал нь мөн юм бол энийг 27 оны төлөвлөгөөнд жишээ нь та бүхэн оруулж ирээч гэж байгаа юм.

Тэгээд энэнтэй уялдсан байдлаар 27 оны төсөв дээр энэ ажлыг эхлүүлмээр байна. Энэ хэн нэгэнд таалагдах асуудал ерөөсөө биш, улс орны хөгжлийн амин чухал салбар учраас энийг заавал та бүхэн төлөвлөлтдөө оруул гэж байгаа юм. Тэрний төлөө Эдийн засаг, хөгжлийн яам өөрөө энэ асуудлаа барьж байгаа учраас би дээр таныг манлайлал үзүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Гишүүн үг хэлчихлээ. Баярлалаа. Байнгын хороодын гишүүд болон Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй тул Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан миний бие өөрөө танилцуулчихъя, тэнд давхар суудаг учраас. Ажлын хэсэгт баярлалаа.

15.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал дээр Байнгын хорооны гишүүдэд сайн мэдээ байна. Байнгын хорооны тогтоолын төсөл, энэ нөгөө цаглавар батлах тухай төсөл байгаа. Гэвч өнөөдөр яг одоо нэр бүхий гишүүд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын суурь хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтүүд оруулж байгаа хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн барьж байна. Уг нь дараа долоо хоног гэж төлөвлөж байсан боловч ингээд нааш нь татаад, өнөөдөр өргөн барьчихаж байгаа юм байна. Тэгэхээр энэ цаглавараа хэдүүлээ нэг мөр дараагийн хурал дээрээ хэлэлцье. Тэгэхгүй бол өнөөдөр баталчихдаг, дараагийн хурал дээр дахиад өөрчлөх асуудал гарах гээд байна. Тэгэхээр ингээд энэ 4 дүгээр асуудлаа хойшлуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудаа хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА